ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЙЛАН
2021-2022 ОН

ТАЙЛАН ХЯНАСАН: Н.ГАНТУЛГА (*Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга*)
ТАЙЛАН ЭМХЭТГЭЖ БОЛОВСРУУЛСАН: М.МӨНХЗУЛ *(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)*

Мандалговь 2023 он

Агуулга

Удиртгал..............................................................................................................................

Нэгдүгээр бүлэг

1. Цаг агаар, уур амьсгалын төлөв байдал, өөрчлөлтийн хандлага
   - 1.1. Цаг агаар, уур амьсгалын тойм.........................................................................................
   - 1.2. Байгалийн гамшигт үзэгдэл, түүний өөрчлөлт
     - 1.2.1. Агаар мандлын аюултай үзэгдэл...........................................................................
     - 1.2.2. Усны үер
     - 1.2.3. Ган, зудын байдал
     - 1.2.4. Шороон шуурга
     - 1.2.5. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа
     - 1.2.6. Газар хөдлөл, түүний нөлөө

Хоёрдугаар бүлэг

2. Байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт
   - 2.1. Газрын нэгдмэл сангийн төлөв байдал
   - 2.2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, ашиглалт
   - 2.3. Цөлжилтийн төлөв байдал
   - 2.4. Уул уурхайн ашиглалтын үеийн байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, байгаль орчны үнэлгээ
   - 2.5. Усны нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт
     - 2.5.1. Гадаргын усны нөөц
     - 2.5.2. Газрын доорх усны нөөц
     - 2.5.3. Усны нөөцийн хамгаалалт
     - 2.5.4. Усны нөөцийн ашиглалт
   - 2.6. Ойн нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт
     - 2.6.1. Ойн нөөц
     - 2.6.2. Ойн нөөцийн хамгаалалт
     - 2.6.3. Ойн нөхөн сэргээлт
   - 2.7. Байгалийн ургамлын нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт
     - 2.7.1. Ургамлын төрөл зүйлийн тархац, хамгааллын арга хэмжээ
   - 2.8. Амьтны нөөцийн хамгаалалт, ашиглалт
     - 2.8.1. Амьтны нөөц
     - 2.8.2. Амьтны ашиглалт
     - 2.8.3. Амьтны хамгаалалт
   - 2.9. Байгаль орчны эсрэг гэмт хэргийн байдал

Гуравдугаар бүлэг

3. Байгаль орчны бохирдол, өөрчлөлтийн төлөв
   - 3.1. Агаарын бохирдол
   - 3.2. Усны бохирдол
   - 3.3. Хог хаягдал
   - 3.4. Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ

Дөрөвдүгээр бүлэг

4.1. Салбарын эрх зүйн өнөөгийн байдал

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

| | |
|---|---|
| ЗГҮАХ | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр |
| МУЭЗНХҮЧ | Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| АЭЗНХҮЧ | Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| ЗДҮАХ | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр |
| ХОХБТХ | Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс |
| МХГ | Мэргэжлийн хяналтын газар |
| ИГЧБЦГХЗахиргаа | Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа |
| ТХГазар | Тусгай хамгаалалттай газар |
| УГГХДТСГЗахиргаа | Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа |
| УТХГ | Улсын тусгай хамгаалалттай газар |
| УЦУОШТөв | Ус, цаг уур, орчны шинжилгээний төв |
| ААН | Аж ахуйн нэгж |
| АЖХ | Аялал жуулчлалын холбоо |
| БОНБҮЕД | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ ерөнхий дүгнэлт |
| БОМТ | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө |
| БХНСАХЗ | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал |
| ОНТ | Орон нутгийн төсөв |
| ТХЗ | Тогтвортой хөгжлийн зорилт |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| МБОАБТ | Монголын байгаль орчин, аюулгүй байдлын төв |
| БОНХС | Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд |
| БОАЖС | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд |
| ЭМС | Эрүүл мэндийн сайд |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| ОЖД | Олон жилийн дундаж |
| ХХААЯ | Хүнс, хөдөө, аж ахуйн яам |

## Удиртгал

Байгаль орчин, аялал жуулчлалын тэргүүлэх чиглэл болох байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг судлан шинжлэх, байгаль орчныг хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахтай холбогдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээнд шинжлэх ухааны ололт, ногоон технологи нэвтрүүлэхэд урамшууллын болон зохицуулалтын хөшүүрэг ашиглах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мэдлэг олгох, байгаль орчны салбарын ажилтан, албан хаагчдад салбарын цаашдын хөгжлийг дээшлүүлэх, олон нийтийг мэдээллээр хангах үүднээс энэхүү тайланг гаргаж анх удаагаа хэвлэмэл байдлаар гаргасан болно. Нийгмийн хөгжлөө дагаад байгаль орчны салбарт болон иргэдийн амьдралд технологийн хөгжлийн нөлөө ихэсч, санхүүгийн боловсрол нэмэгдэхийн хэрээр бодит тоо баримт, судалгаа, шинжилгээ аливаа салбарын цаашдын бодлого төлөвлөлт, чиг хандлага, хөгжилд чухал ач холбогдолтой болоод байна.

Байгаль орчны төлөв байдлын тайланг 2 жилд 1 удаа гаргадаг бөгөөд 2017-2018 оны аймгийн хэмжээний тайланг боловсруулж, ном болгон хэвлүүлж, 15 сум, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг мэдээллээр хангах зорилгоор тараасан. 2019-2020 оны төлөв байдлын тайланг гаргаж, 2021-2024 оны бодлогын баримт боловсруулалт, байгаль орчны чиглэлийн төсөл хөтөлбөр боловсруулахад суурь судалгаа болгон ашиглав. Байгаль орчны төлөв байдлыг тайлангийн зорилго нь байгаль орчны одоогийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгч, бодлого төлөвлөгөө боловсруулахад суурь мэдээлэл болох юм.

Тайлангийн 1 дүгээр бүлэгт цаг агаарын төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх сүүлийн жилүүдийн цаг уурын ажиглалтын дэлгэрэнгүй мэдээллийг Ус, цаг уур орчны шинжилгээний төвөөс авч оруулав.

Тайлангийн 2 дугаар бүлэгт байгалийн баялгийн нөөцийн өнөөгийн төлөв байдал, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн мэдээ, тоо баримтыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Сум дундын ойн анги болон холбогдох тайлангуудаас авч нэгтгэн боловсруулав.

Тайлангийн 3 дугаар бүлэгт байгаль орчны бохирдлын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаарх мэдээ, тоо баримтыг холбогдох судалгаа, шинжилгээний ажил, тайлангуудад үндэслэн нэгтгэн боловсруулав.

Тайлангийн 4 дүгээр бүлэгт байгаль орчны засаглалын өнөөгийн байдал, ногоон хөгжлийн зорилтын талаарх тоо баримт, салбарын эрх зүй, төсөв санхүүгийн холбогдох мэдээлэл болон аялал жуулчлалын талаарх мэдээллийг нэгтгэн тусгав.

## Нэгдүгээр бүлэг. Цаг агаар, уур амьсгалын төлөв байдал, өөрчлөлтийн хандлага

### Дундговь аймгийн 2021-2022 оны цаг агаар, уур амьсгалын тойм

Дундговь аймаг нь Монгол улсын нутгийн төв хэсэгт талархаг нутагт говь хээрийн бүсийн зааг дээр оршдог. Нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөр, Дэлгэрхангай уул юм. Мөн Их, Бага газрын чулуу зэрэг уулс бий. Дундговь аймгийн нутагт Онгийн голоос өөр том гол, нуур байхгүй.

Дундговь аймгийн нутаг боржин чулуутай цохио, толгод, бэсрэг уулс бүхий ухаа гвээрхэг тэгшивтэр нутагт хамаарна. Нийт газар нутгийн талбай 74,690 км квадрат. Далайн түвшнээс дээш 1100-1377 метрт өргөдсөн байдаг.

**Дундговь аймгийн 2021-2022 оны цаг агаар, уур амьсгалын тойм**

Дундговь аймаг нь Монгол улсын нутгийн төв хэсэгт талархаг нутагт говь хээрийн бүсийн зааг дээр оршдог. Нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөр, Дэлгэрхангай уул юм. Мөн Их, Бага газрын чулуу зэрэг уулс бий. Дундговь аймгийн нутагт Онгийн голоос өөр том гол, нуур байхгүй.

Дундговь аймгийн нутаг боржин чулуутай цохио, толгод, бэсрэг уулс бүхий ухаа гүвээрхэг тэгшивтэр нутагт хамаарна. Нийт газар нутгийн талбай 74,690 км квадрат. Далайн түвшнээс дээш 1100-1377 метрт өргөдсөн байдаг.

**Агаарын температур:** Дундговь аймгийн олон жилийн агаарын дундаж температур /1991-2021он/ нь 1,1....4,5 градусын хооронд хэлбэлздэг байна. 2021 онд 2,4...5,4 градус, 2022 онд 1,3...4,5 градус байгааг олон жилийн дундажтай харьцуулахад 2021 онд нийт нутгаар 1,0...1,3 градусаар дулаан, 2022 онд Говь-угтаал, Дэрэн сумдын нутгаар -0,1 градусаар хүйтэн, бусад нутгаар 0,2...1,5 градусаар дулаан байсан байна (Зураг 1).




Зураг 1. Дундговь аймгийн агаарын дундаж температур /2021, 2022 он/

Агаарын жилийн дундаж температурыг дундчилж үзвэл 2021 онд 1,1 градус, 2022 онд 0,3 градусаар олон жилийн дундажаас дулаан байжээ (Зураг 2).




Зураг 2. Дундговь аймгийн жилийн агаарын дундаж температур /2021, 2022 он/

Агаарын хамгийн их температур нь 2021 онд 25,0...36,0 градус хүрч, агаарт +30 градусаас дулаан өдөр 9-35, 2022 онд 32,2...37,1 градус хүрч, агаарт +30 градусаас дулаан

өдөр 8-46 байсан. 2021 онд агаарын хамгийн их утга Гурвансайхан суманд 36,2 градус, 2022 онд Өлзийт суманд 37,1 градус хүрч тус тус ажиглагдсан байна.  (Зураг 3).




Зураг 3. Агаарын хамгийн их температурын тархалт /2021,2022 он/




Зураг 4. Агаарт +30 градусаас дулаан өдрийн тоо /2021, 2022 он/

Агаарын хамгийн бага температур нь 2021 онд -30,8...-38,4 градус хүрч агаарт -30 градусаас хүйтэн өдөр 1-10, 2022 онд -27,0...-31,8 хүрч агаарт -30 градусаас хүйтэн өдөр 1-3 ажиглагдсан байна. 2021 онд Цагаандэлгэр суманд -38,4 градус, 2022 онд Говь-Угтаал суманд -31,8 градус хүрч тус тус ажиглагдсан байна (Зураг 5).




Зураг 5. Агаарт -30 градусаас хүйтэн өдрийн тоо /2021, 2022 он/

**Хур тунадас:** Дундговь аймгийн нутгаар олон жилийн дундажаар 96,1-209мм хур тунадас унадаг байна. 2021 онд нийт нутгаар жилдээ 55,7-244,8мм хур тунадас орсон бөгөөд Өндөршил суманд олон жилийн дунджаас бага, Эрдэнэдалай, Говь-Угтаал, Сайхан-Овоо, Хулд, Дэлгэрхангай, Дэрэн сумдаар олон жилийн дунджаас ахиу, бусад сумдаар олон жилийн дунджийн орчим хур тунадас орсон. 2022 онд нийт нутгаар жилдээ 35,6-260,8мм хур тунадас орсон бөгөөд Сайхан-Овоо, Хулд, Дэлгэрхангай, Өлзийт, Баянжаргалан сумдаар олон жилийн дунджаас бага, Говь-Угтаал, Адаацаг, Дэрэн сумдаар олон жилийн дунджаас ахиу, бусад сумдаар олон жилийн дунджийн орчим хур тунадас орсон. Жилийн нийлбэр хур тунадасны хэмжээгээр хамгийн их нь 2021 онд Цагаандэлгэр суманд 244,8мм, 2022 онд Дэрэн суманд 260,8мм хур тунадас орсон байна. Хамгийн бага нь 2021 онд Өндөршил суманд 55,7 мм, 2022 онд Өлзийт суманд 35,6мм хур тунадас орсон (Зураг 6).




Зураг 6. Жилийн нийлбэр хур тунадас, мм /2021, 2022 он/

Хур тунадасыг 4-10 дугаар сарыг дулааны улирал, 11-03 дугаар сарыг хүйтний улирал гэж авч үзвэл дулааны улиралд 2021 онд 51,9-238,5мм хур тунадас, 2022 онд 34,6-253,9мм хур тунадас орсон. Харин хүйтний улиралд 2021 онд 1,5-7,6мм хур тунадас, 2022 онд 1,2-12,0мм хур тунадас орсон. Үүнээс үзвэл  жилийн нийлбэр хур тунадасны ихэнх хувийг дулааны улирлын хур тунадас эзэлдэг бөгөөд энэ нь халалтаас үүсдэг конвекцийн үзэгдлүүд, мөн дулааны улиралд явагддаг цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаатай холбоотой юм. (Зураг 7,8).




Зураг 7. Дулааны улирлын хур тунадас /2021, 2022 он/




Зураг 8. Хүйтний улирлын хур тунадас /2021, 2022 он/

1. Хүчтэй салхи

Хүчтэй салхийг Засгийн газрын 286-р тогтоолд зааснаар салхины дундаж хурд 15 м/с ба түүний их болоход “аюултай үзэгдэл”, 28 м/с ба түүний их болоход “Онц аюултай үзэгдэл” гэж үздэг. 2021-2022 онд ажиглагдсан хүчтэй салхитай өдрийн тооноос харвал 2021 онд Гурвансайхан суманд 36 өдөр ажиглагдаж байсан бол 2022 онд Говь-Угтаал суманд 29 өдөр ажиглагдаж байжээ.




2. Шороон шуурга

Шороон шуурганы үзэгдлийг Засгийн газрын 286-р тогтоолд зааснаар шороон шуурга шуурч алсын барааны харагдац 1000 метр болоход “Аюултай үзэгдэл”, харин 20 метр болоход “Онц аюултай үзэгдэл” гэж үздэг. Шороон шуургатай өдрийн тоо 2021 онд Сайхан-Овоо сумын нутгаар 50 өдөр, 2022 онд мөн Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдын нутгаар 20 өдөр ажиглагдсан нь хамгийн олон тохиолдол юм.




3. Цасан шуурга

Цасан шуурганы үзэгдлийг Засгийн газрын 286-р тогтоолд зааснаар цасан шуурга шуурч алсын барааны харагдац 1000 метр болоход “Аюултай үзэгдэл”, харин 20 метр болоход “Онц аюултай үзэгдэл” гэж үздэг. Цасан шуугатай өдрийн тооноос харвал 2021 онд Сайнцагаанд 17 өдөр, 2022 онд Эрдэнэдалайд 21 өдөр ажиглагдсан нь хамгийн олон тохиолдол юм.




4. Аадар бороо

Сүүлийн жилүүдэд нийт нутгийг хамарсан зүс бороо, шиврээ бороотой өдрийн тоо багасч халалтаас үүсэх, богино хугацаанд эрчимшил ихтэй ажиглагдах конвекцийн үзэгдэл буюу аадар бороотой өдрийн тоо ихсэж түүнийг дагаад хүчтэй нөөлөг салхи, аянга цахилгаантай өдрийн тоо ихсэж улс ардын амьдралд учруулах хохирол нь өссөөр байна. Аадар бороо 2021 онд Дэрэнд 45 өдөр, 2022 онд Луust 41 өдөр ажиглагдсан нь хамгийн олон тохиолдол юм.




Дундговь аймгийн УЦУОШТөвийн Мэдээлэл үйлчилгээний хэлтсээс гаргадаг аюултай үзэгдлийн судалгаанаас дурдвал:

1. 2021.03.14-нд Дундговь аймгийн нутгаар салхи баруун, баруун хойноос Эрдэнэдалай суманд 34 м/с, Сайхан-Овоо, Сайнцагаан, Гурвансайхан, Говь-Угтаал, Баянжаргалан сумдаар 28 м/с, бусад сумдаар 16-24 м/с хүчтэй салхи ажиглагдсан. Салхины өрөвхийлөлт нь Эрдэнэдалай, Сайнцагаан сумдаар түр зуур 40 м/с хүрч ширүүссэн. Энэ үеэр нийт нутгаар шороон шуурганы гамшигт үзэгдэл ажиглагдаж үзэгдэх орчин харагдахгүй 8 цаг харанхуйлсан ба үргэлжилсэн хугацаа хамгийн бага нь Баянжаргалан суманд 06 цаг 26 минут, хамгийн их нь Эрдэнэдалай суманд 10 цаг 25 минут ажиглагдсан. Хүчтэй салхины үргэлжилсэн хугацаа дунджаар 11 цаг, 28 м/с буюу түүнээс их онц аюултай үзэгдлийн үргэлжилсэн хугацаа дунджаар 3 цаг ажиглагдсан. Энэ үед 468 хүн төөрснөөс, зүүн талын сумдын 9 хүний амь үрэгдэж, 2,171,512 мал урууджаж, 137205 мал хорогдсон, 138 гэр нурж, 587 хашаа нурсан, 69 байшингийн дээвэр хуурсан, 30 авто машины цонх хагарч, будаг нь халцарсан, олон цагаар гэрэл, цахилгаан тасалдаж, Баянжаргалан ЦДАШ-н тулгуур №342-348 хооронд 7 ширхэг тулгуур хүчтэй салхины улмаас унасан, Сайхан-Овоо сумын шилэн кабель гэмтэж, аж ахуй нэгж, малчид, ард иргэдэд асар их хэмжээний хохирол учруулсан төдийгүй бэлчээрийн хөрс элсээр шуурч, элсэн хунгар үүссэн, ургамлын үндэс ил гарсан. Нийт 2,177,788 тоо толгой мал урууудсанаас 1,973,234 тоо толгой мал амьд олдож, 137205 тоо толгой мал хорогдож 67,349 тооны мал олдоогүй байна.
2. 2021.04.14-нд Дундговь аймгийн нийт нутгаар хүчтэй салхи салхилж, Луус, Адаацаг, Сайнцагаан сумдаар онц аюулын хэмжээнд буюу 28 м/с, Гурвансайханд 25 м/с, бусад сумдаар 18-20 м/с хүрч Баянжаргалан, Луус, Өндөршил, Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт, Сайнцагаан сумдаар 11-15 цаг, бусад сумдаар 3-8 цаг үргэлжилсэн ба онц аюулын үргэлжилсэн хугацаа 27 минутаас 1 цаг 14 минут. Мөн нутгийн зүүн сумдаар цас орж, орон шуурга 2-9 цаг үргэлжилсэн. Нийт нутгаар шороон шуурга шуурч, нутгийн 50 гаруй хувьд онц аюулын хэмжээнд буюу хараа 20 метрт орж харнхулсан ба бусад нутгаар хараа 200 метрт орж харанхуйлсан байна. Энэ үзэгдэл нийт 3-10 цаг үргэлжилсэн. Онц аюулын үргэлжилсэн хугацаа Адаацагт 8 минут, бусад сумдаар 1 цагаас 5 цаг 04 минут үргэлжилжээ.

3. 2021.05.05-нд Дундговь аймгийн нийт нутгаар хүчтэй салхи салхилж, Өлзийт, Өндөршил, Гурвансайхан сумдаар онц аюулын хэмжээнд буюу 28 м/с, бусад сумдаар 18-24 м/с хүрч, Сайнцагаан, Говь-Угтаал, Өндөршил, Гурвансайхан сумдаар 18-20 цаг, бусад сумдаар 2-12 цаг үргэлжилсэн. Онц аюулын үргэлжилсэн хугацаа 1-3 цаг. Мөн нийт нутгаар шороон шуурга шуурч Гурвансайханд онц аюул буюу хараа 20 метрт орж харанхуйлсан ба нийт 2-9 цаг үргэлжилсэн. Онц аюулын үргэлжилсэн хугацаа 2 цаг 10 минут. Нутгийн зүүн сумдаар цас орж, Цагаандэлгэр, Говь-Угтаал суманд орон шуурга онц аюулын хэмжээнд хүрч ширүүссэн ба Говь-угтаал суманд 17,0 мм, Цагаандэлгэр суманд 6,0 мм, Гурвансайхан, Дэрэн сумдаар 0,2 мм цас орсон. Энэ үед 9 айлын гэр нурж, 5 байшингийн дээвэр хуурж, 69 айлын хашаа нурж, нийт 342 айлын 9325 мал хорогдсон байна.

4. 2022.03.14-нд Дундговь аймгийн 50 гаруй хувьд хүчтэй салхи салхилж, Сайхан-Овоо, Луус, Дэлгэрхангай, Хулд сумдын нутгаар давтан аюулын хэмжээнд буюу 20 м/с, бусад сумдаар 15-16 м/с хүрч Луус, Дэлгэрхангай сумдаар 2-3 цаг, бусад сумдаар 30 минутаас 1 цаг 30 минут үргэлжилсэн. Мөн 50 гаруй хувьд цас орж, орон шуурга шуурч Луус суманд давтан аюулын хэмжээнд буюу хараа 200 метрт орж харанхуйлсан ба 2 цаг 30 минут үргэлжилсэн.

Дундговь аймгийн УЦУОШТөвийн Мэдээлэл үйлчилгээний хэлтэс

## 2. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

### 2.1. Газрын нэгдмэл сангийн төлөв байдал

Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас нэгтгэн гаргадаг газрын нэгдмэл сангийн тайлан БОХ 1.1 маягтын дагуу Дундговь аймгийн газрын нэгдмэл санд 2022 оны жилийн эцсийн байдлаар хөдөө аж ахуйн газар 6556510.86 га, хот тосгон бусад суурин газар 22774.64 га, зам шугам сүлжээний газар 386271.06 га, ойн сан бүхий газар 32759 га, усны сан бүхий газар 7796 га, улсын тусгай хэрэгцээний газар 427066.8 га талбайг тус тус эзэлж байна.




Газрын нэгдмэл сангийн 2021-2022 оны тайланг харьцуулахад зам шугам сүлжээний газар 354844.31 га-аар нэмэгдэж, хөдөө аж ахуйн газар 356080.62 га-аар, уурхайн газар 1201.65 га-аар, нийтийн эдэлбэр газар 175.99 га-аар, барилга байгууламжийн дэвсгэр газар 37.80 га-аар тус тус нэмэгдсэн өөрчлөлттэй байна. Улсын тусгай хамгаалалттай газар, усны сан бүхий газар, ойн сан бүхий газарт өөрчлөлт байхгүй.

Аймгийн газрын нэгдмэл сангийн ангилал /га/

| № | Газрын нэгдмэл сангийн ангилал | 2021 | 2022 | Зөрүү |
|---|---|---|---|---|
| | Хөдөө аж ахуйн газар | 6912591.48 | 6556510.86 | 356080.62 |
| 1 | Бэлчээрийн газар | 6908383.60 | 6552178.52 | 356205.08 |
| 2 | Хадлангийн талбай | - | | |
| 3 | Тариалангийн талбай | 806.56 | 838.29 | 31.73 |
| 4 | Атаршсан газар | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар | 3388.3 | 3481.05 | 92.75 |
| 6 | ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар | 13 | 13 | 0 |
| | Хот, тосгон бусад суурины газар | 21631.36 | 22774.64 | 1143.28 |
| 7 | Барилга байгууламжийн дэвсгэр газар | 648.25 | 686.05 | 37.80 |
| 8 | Нийтийн эдэлбэр газар | 7269.66 | 7093.67 | 175.99 |
| 9 | Үйлдвэрийн газар | 11.64 | 11.64 | 0 |
| 10 | Уурхайн газар | 12200.30 | 13401.95 | 1201.65 |
| 11 | Гэр хорооллын газар | 1501.51 | 1581.33 | 79.82 |
| | Зам шугам сүлжээний газар | 31426.75 | 386271.06 | 354844.31 |
| 12 | Авто замын газар | 25731.8 | 25731.8 | 0 |
| 13 | Төмөр замын газар | 480 | 480 | 0 |
| 14 | Агаарын тээврийн газар | 46.7 | 46.7 | 0 |
| 15 | Шугам сүлжээний газар | 5168.25 | 360012.56 | 354844.31 |
| 16 | Усан тээврийн буудлын газар | - | - | - |
| | Ойн сан бүхий газар | 32.76 | 32.76 | 0 |
| 17 | Ой модоор бүрхэгдсэн газар | 16.86 | 16.86 | 0 |
| 18 | Ой модыг нь огтолсон газар | | | |
| 19 | Мод үржүүлгийн газар | | | |
| 20 | Ой тэлэн ургах нөөц газар | | | |
| 21 | Ойн сангийн бусад газар | 15.91 | 15.91 | 0 |
| | Усны сан бүхий газар | 7796 | 7796 | 0 |
| 22 | Гол мөрний эзлэх газар | 48 | 48 | 0 |
| 23 | Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар | 7467.5 | 7467.5 | 0 |
| 24 | Горхи, булаг, шандны эзлэх газар | 280.5 | 280.5 | 0 |
| 25 | Мөнх цаст, мөсөн голын эзлэх газар | - | - | - |
| | Улсын тусгай хэрэгцээний газар | 427066.8 | 427066.8 | 0 |
| 26 | Улсын тусгай хамгаалалттай газар | 426413 | 426413 | 0 |
| 27 | Улсын хилийн зурвасын газар | - | - | - |
| 28 | Улсын батлан хамгаалах зориулалтын газар | 639.03 | 639.03 | 0 |
| 29 | Гадаадын дипломат, консул, төлөөлөгчийн газар | - | - | - |
| 30 | ШУ, туршилт, цаг уурын ажиглалтын талбай | 14.83 | 14.83 | 0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 31 | Аймаг дундын отрын бэлчээр | - | - | - |
| 32 | Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай | - | - | - |
| 33 | Газрын тосны гэрээт талбай | - | - | - |
| 34 | Чөлөөт бүсийн газар | - | - | - |
| Нийт дүн | | 7469032.00 | 7469032.00 | |

## 2.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, ашиглалт

### Тусгай хамгаалалттай газрын ерөнхий мэдээлэл

2022 оны байдлаар Дундговь аймагт 4 улсын тусгай хамгаалалттай газар, 18 аймгийн тусгай хамгаалалттай газар, 216 сумын тусгай хамгаалалттай газар байгаа бөгөөд нийт газар нутгийн 28.7 хувийг эзэлж байна. *(График 1-т тусгав)*

*График 1*




2022 оны байдлаар улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 12 байгаль хамгаалагч ажиллаж байна.

### 2.2.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг

Дундговь аймагт улсын тусгай хамгаалалттай 4 газар байна. 1996 онд Загийн усны хоолой , 2011 онд Бага газрын чулуу, Дэлгэрхангай уул, 2012 онд Их газрын чулууг тус тус улсын тусгай хамгаалалтад авав.(Хүснэгт 1)

*Хүснэгт 1 Улсын тусгай хамгаалалттай газрын ерөнхий мэдээлэл*

| Д/д | Сумын нэр | Газрын нэр | УИХ-ын тогтоолын огноо, дугаар | Талбайн га | | Ангилал | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нийт талбай | Эзлэх хувь | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Өлзийт | Загийн усны хоолой | 1996.5.7 №43 | 189465 | 12,29 | Байгалийн нөөц газар | Хужир мараа, заган ой, шал тойром, довцог, элсэн манхан хослон оршдог экологийн өвөрмөц орчин, хар сүүлт цагаан зээрийн тархалтын баруун хойт хязгаар |
| 2. | Говь-Угтаал, Гурван сайхан | Их газрын чулууны уул | 2012.5.23 №57 | 175906 | 26,05 | Байгалийн цогцолборт газар | Ховор ан амьтан, ургамалтай, байгалийн өвөрмөц тогтоцтой, үзэсгэлэнт газар |
| 3. | Дэлгэр цогт | Бага газрын чулуу | 2011.01.20 №04 | 2718 | 1.09 | Байгалийн дурсгалт газар | Ховор ан амьтан, байгалийн өвөрмөц тогтоцтой, үзэсгэлэнт газар |
| 4. | Дэлгэр хангай | Дэлгэрхангай уул | 2011.01.20 №04 | 58324 | 9.39 | Байгалийн нөөц газар | Ховор ан амьтан, ургамалтай, байгалийн үзэсгэлэнт газар |
| Нийт | | | | **426413** | | | |

*Улсын тусгай хамгаалалттай газрын ангилал*




***Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газрууд нь хамгаалалтын захиргаатай байна гэж заасны дагуу Дундговь аймгийн Их газрын чулуу байгалийн цогцолборт газрыг хариуцан хамгаалалтын захиргаа ажиллаж байна.***

**Их газрын чулууны БЦГ**

Байгалийн үзэсгэлэн, ландшафтын иж бүрдлийг хамгаалах зорилгоор 2003 онд Засгийн газрын тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авсан юм. Улмаар 2012 онд УИХ-ын 57 дугаар тогтоолоор Их газрын чулууны байгалийн нөөц газрыг байгалийн цогцолборт газар болгон нийт 175,906 га талбайг өргөтгөж ангиллыг дээшлүүлсэн байна.

Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А-06 дугаар тушаалаар батлагдсан "Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын бүтэц, орон тооны жишиг болон сургалт, мэдээллийн төвүүдийн байршлыг батлах тухай" тушаал гарч Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа байгуулагдсан.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Б-55 тоот тушаалаар даргыг томилсноор үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь үндсэн 13 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгалийн цогцолборт газрын дотоод бүсчлэл







| Дотоод бүс | Говь-Угтаал | Гурван сайхан | Өлзийт | Нийт (га) |
|---|---|---|---|---|
| Онцгой бүс"А" | 615.3 | 185.1 | | 800.4 |
| Онцгой бүс"Б" | | 7976.2 | | 7976.2 |
| Аялал жуулчлалын бүс"I" | 5213.7 | 8669.6 | | 13883.3 |
| Аялал жуулчлалын бүс"II" | | 32158.3 | 79.5 | 32237.9 |
| Аялал жуулчлалын бүс"III" | | 11151.8 | | 11151.8 |
| Хязгаарлалтын бүс | 10355.8 | 92799.6 | 6701.6 | 109857 |
| **Нийт** | | | | **175906.1** |
| Орчны бүс | 15908.14 | 128630.9 | 29460.6 | 174000 |

Масштаб 1:340 000

Ландшафт

Зүүн уртрагийн 107 хэм 13%, хойд өргөргийн 45 хэм 48%-д Говь-Угтаал, Гурвансайхан сумын нутгийн уулзварт уртаараа 30 орчим, өргөөшөө 15 км сунаж тогтсон 600 шахам ам км талбайг эзлэн хойшоо, урагшаа, баруун, зүүн тийшээ гудамжлан эгнэсэн, далайн түвшнээс 1565-1709 метр өргөгдсөн боржин, асмалжин, толбожин гэх мэтийн гүний чулуулаг, пермь, цэрд, гурав дахь галвын элсэн чулуу, нүүрслэг занар, алаг мөлгөр хөрзөн, шохойн чулуунаас тогтсон хад байцсын чуулга юм.

Байгалийн цогцолборт газарт цагаан зээр, бор туулай, алаг даага, хонин гүрвэл, огдой, монгол тарвага, үнэг, чоно зэрэг хөхтөн амьтнаас гадна олон улсын хэмжээнд ховордсон, устаж болзошгүй эмзэг амьтны зэрэглэлд орсон аргаль хонь, янгир ямаа нутагладаг. Алаг даага, хадны борогчин, монгол чичүүл зэрэг мэрэгчид, сахалт багваахай, жижиг соотон багваахай зэрэг гар далавчтан, тас, бүргэд, харцага, ногтруу, хээрийн тагтаа, болжмор зэрэг жигүүртэн, аргаль, янгир, шилүүс, үнэг, хярс, тарвага, туулай, зээр зэрэг 20 гаруй төрлийн ан амьтан амьдрана.

Нөмрөг тас, Ооч ёл, Хээрийн бүргэд ,Элээ, Начин шонхор, ногтруу, сахиа зэрэг шувуу бүртгэгдсэн.

Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт 34 овог, 97 төрөл, 152 зүйлийн ургамалтай. Мөн монгол орны улаан номонд цөлийн аргамжинцэцэг, ноосон шилбэт баглуур 2 зүйл нэн ховор ургамал, пржевальскийн зээргэнэ, анхил сонгино, ацан ажигана, өргөст ортууз, дагуур хүж өвс, сибирь ерөндгөнө, шаргал шарилж 7 зүйл ховор ургамал ургана.

Их газрын чулууны ууланд "Төв боржигон" жуулчны бааз, "Хишигтэн говь" гэр буудал 5-10 дугаар сард жуулчин хүлээн авч, үйл ажиллагаа явуулдаг.

## ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАРТ ТОХИЖИЛТЫН АЖЛУУД ХИЙГДСЭЭР

| № | Газрын нэр | Тохижилт | Төсөв | Хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Дэлгэрхангай уул (Улсын тусгай хамгаалалтай байгалийн дурсгалт газар) | Хилийн багана, мэдээллийн самбар, орц, гарцын хаалга, био 00 /Зураг 1./ | БХНСАХЗ-11.5 сая төгрөг | 2021 |
| 2 | "Дэл уул, Цагаан суварга" (Аймгийн тусгай хамгаалалттай) | Ландшафтын хүрээ, хаалт, тэмдэг тэмдэглэгээ, нарны зайгаар ажилладаг гэрэл, сүүдрэвч, био 00, сүүдрэвч, мэдээллийн самбар, хаалт, хогийн сав /Зураг 2./ | Улсын төсөв-40.0 сая төгрөг | 2021 |
| 3 | "Загийн усны хоолой" (Улсын тусгай хамгаалалттай газар) | Хилийн багана /Зураг 3./ | БХНСАХЗ-6.8 сая төгрөг | 2021 |
| 4 | "Бага газрын чулуу" (Улсын тусгай хамгаалалттай газар) | мэдээллийн самбар бүхий угтах хаалга /Зураг 4./ | БХНСАХЗ-5.0 сая төгрөг | 2022 |
| Нийт | | | **63.3 сая төгрөг** | |

"ДЭЛГЭРХАНГАЙ УУЛ"






Зураг 1.

“ДЭЛ УУЛ, ЦАГААН СУВАРГА”




Зураг 2.

“ЗАГИЙН УСНЫ ХООЛОЙ”



*Зураг 3.*

“БАГА ГАЗРЫН ЧУЛУУ”




*Зураг 4.*

2022 оны байдлаар Тусгай хамгаалалттай газарт 8 байгаль хамгаалагч ажиллаж байна.

| № | Сумын нэр | Байгаль хамгаалагчийн овог, нэр | Хариуцдаг газрын нэр | Хариуцсан талбай га |
|---|---|---|---|---|
| 1 | Дэлгэрцогт | Пүрэв Батсайхан | Бага газрын чулууны уул, сүм хөх бүрд орчмын байгаль хамгаалагч | 59830 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Дэлгэрхангай | Цэдэндамба Өлзийбат | Дэлгэрхангай уул орчмын байгаль хамгаалагч | 173400 |
| 3 | Өлзийт | Нэрхүү Гомборагчаа | Загийн ус орчмын байгаль хамгаалагч | 171800 |
| 4 | Баянжаргалан | Төмөр-Ухна Баярсайхан | Аргын хад, Хүрэн дух, Эрээн орчмын байгаль хамгаалагч | 181400 |
| 5 | Гурвансайхан | Нацаг Ганхуяг | Уул-Гурвансайхан орчмын байгаль хамгаалагч | 146600 |
| 6 | Сайнцагаан | Бархас Бадамханд | Суман хайрхан, Тогоогийн рашаан орчмын байгаль хамгаалагч | 186540 |
| 7 | Өлзийт | Батбуян Бадрах | Дэл уул, Цагаан суварга орчмын байгаль хамгаалагч<br>Хөнжлийн уул | 215100 |
| 8 | Сайхан-Овоо | - | Онгийн хийд орчмын байгаль хамгаалагч | 173400 |

**2.3. Цөлжилтийн өнөөгийн байдал.**

Цөлжилт, газрын доройтлын зураглал, тайлан гаргах судалгаа 5 жилд 1 удаа хийгддэг.

Монгол орны цөлжилтийн үйл явцыг үнэлж дүгнэх, зураглах ажил 1990-ээд оноос эхэлж, цөлжилтийн анхны зургийг Газарзүйн хүрээлэн Туркменистаны Цөл судлалын хүрээлэн хамтран 1989 онд боловсруулсан ба цөлжилтийн үйл явцыг зөвхөн гандуу нутгийн буюу говь цөлийн хэмжээнд үнэлэн зурагласан. Харин 2 дахь зургийн Геоэкологийн хүрээлэн 2001 онд боловсруулж цөлжилт, газрын доройтол болон бэлчээрийн доройтлын үйл явцыг тус тусад нь зурагласан бол 3 дахь зургийг 2006 онд боловсруулж, зайнаас тандан судлал, газарзүйн мэдээллийн системийг ашигласан. Цөлжилтийн 4 дэх зургийг тус хүрээлэн нь БОАЖЯ-ны харъяа Байгаль орчны мэдээллийн төвтэй хамтран 2010 онд шинэчлэн боловсруулж, зайнаас тандан судлал, тоон ба физик загвар ашиглан зураглаж, “Гандуу нутгийн газрын доройтлыг үнэлэх” (LADA) хөтөлбөрийн аргазүйг ашигласан бөгөөд уг ажил нь Швейцарын хөгжлийн агентлагийн “Цөлжилтийг сааруулах нь” хөтөлбөрийн хүрээнд 2008-2013 онд хэрэгжүүлсэн “Цөлжилт, газрын доройтлын үнэлгээ, зураглал” төслийн үр дүн юм. Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн нь 2020 онд БОАЖЯ-ны захиалгаар “Монгол улсын газрын доройтол, цөлжилтийн атлас зураглал хийх, тайлан гаргах” ажлыг нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэв. Монгол орны цөлжилтийн байдлыг илтгэх нийт 30 гаруй үзүүлэлтийг тооцоолж, тэдгээрээс дараах 18 үзүүлэлтийг сонгон авч нэгтгэн боловсруулж, цөлжилтийн зургийг гаргасан.

Цөлжилтийн зургаас харвал 2020 оны байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76,9% нь ямар нэг хэмжээгээр цөлжилтөд өртсөн бөгөөд үүнээс 31,5% нь сул, 22.1% нь дунд, 18.6% нь хүчтэй, 4.7% нь нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна.




Аймгийн дүнгээр авч үзвэл Дундговь, Өвөрхангай, Говьсүмбэр, Дорноговь, Баянхонгор, Төв, Говь-Алтай, Өмнөговь аймгуудын нутаг цөлжилтөд илүү их өртөөд байна.

Дундговь аймгийн газар нутаг нийтдээ ямар нэгэн хэмжээгээр цөлжилтөд өртсөн бөгөөд газар нутгийн 54.8% нь хүчтэй, 30.9% нь нэн хүчтэй, 13% нь дунд зэрэг, 1,3% нь сул зэрэглэлд хамрагдаж байна.






*2020.06.20* *Аймгийн төв*

**Цөлжилтийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ:**




Улсын төсвөөр 2021 онд

- ✓ Сайнцагаан суманд зам дагуу **25 га** талбайд 15000 ширхэг мод
- ✓ 2022 онд Эрдэнэдалай суманд **8 га** талбайд 3360 ширхэг мод тус тус тарилаа.






**2021-2022 ОНД БЭЛЧЭЭРИЙН МЭРЭГЧ АМЬТАН ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ ЭНГИЙН МЕХАНИК АРГААР ТЭМЦСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Дундговь аймаг нь 7469032.00 га газар нутагтай үүнээс хөдөө аж ахуйн эдэлбэр газар 7115047.37 га, бэлчээрийн талбай 7110980.52 га буюу нийт газар нутгийн 95,3 хувийг эзэлж байна.

Аймгийн нийт бэлчээрийн талбайн 20 хувьд бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготно тархсан. 2021 онд 7 сумын 50000.0 га талбайд, 2022 онд 29500.0 га талбайд тэмцэх ажлыг зохион байгуулсан. Нийт сүүлийн 2 жилд 79500.0 га талбайд үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар тэмцэх ажил хийгдсэн.

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар тэмцэх сумдууд, үлийн цагаан оготно тархсан талбайн хэмжээ, тэмцсэн талбайн хэмжээ

| | Он | 2021 | | | 2022 | |
|---|---|---|---|---|---|---|
| Д/д | Сумдын нэр | Үлийн цагаан оготно тархсан талбай мянган/га | Тэмцэх талбайн хэмжээ мян/га | Зарцуулсан төсөв | Тэмцсэн талбайн хэмжээ мян/га | Зарцуулсан төсөв |
| 1 | Эрдэнэдалай | 346259 | 10 | Улсын төсөв 54,424,000 | 8500.0 га | 19.8 сая |
| 2 | Адаацаг | 167961 | 9 | | 3000.0 га | 1.0 сая |
| 3 | Дэлгэрцогт | 102486 | 6 | | 3000.0 га | 1.5 сая |
| 4 | Дэрэн | 193524 | 6 | | - | - |
| 5 | Сайхан-Овоо | 137377 | 6 | | 3000.0 га | 1.0 сая |
| 6 | Говь-Угтаал | 154870 | 6 | | - | - |
| 7 | Цагаандэлгэр | 155476 | 7 | | - | - |
| 8 | Баянжаргалан | - | - | - | 5000.0 га | 16.0 сая |
| 9 | Луус | - | - | - | 3000.0 га | 1.5 сая |
| 10 | Сайнцагаан | - | - | - | 4000.0 га | 4.0 сая |
| **Нийт** | | **1257953** | **50** | | **29500.0 га** | **43.8** |

*2022 онд бэлчээрийн хөнөөлт үлийн цаган оготнотой тэмцэх ажилд Орон нутгийн сангийн 43,8 сая төгрөгийн санхүүжилтээр 05 дугаар сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 10--ны хооронд утагч багаж-16, үлий цөмлөгч-10, Машин-24, мотоцикл-7 ашиглан 15 төрийн албан хаагч 75 малчныг хамруулан 29,5 мянган га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар тэмцсэн.*

Судалгаанд хамрагдсан сумдын бэлчээр, худаг, уст цэг, өвөлжөө хаваржаа, зуслан нутагт хөнөөлт мэрэгч амьтдын тархалт их, дундаж нягтшил нь 1 га талбайд дунджаар эзэнтэй үлий 18 тоологдож байгаа нь ***ихсэх*** төлөвтэй байна цаашид тархац нутаг нь богино хугацаанд тэлж нэмэгдэн бэлчээрийн ургамлан нөмрөг болон мал аж ахуйн салбарт нөлөөлөх хандлагатай байгааг 2021 оны хаврын судалгаагаар тогтоосон .

**Үлийн цагаан оготны тархалтын зураглал**



Хавсралт зураг 1.









**МИКРОБИОЛОГИЙН** АРГААР ТЭМЦСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Дундговь аймгийн зарим сумдад 2021 онд бэлчээрийн мэрэгч амьтан үлийн цагаан оготонотой **микробиологийн** аргаар тэмцсэн бөгөөд 2022 онд микробиологийн аргаар тэмцэх ажил хийгдээгүй.

2021 онд улсын төсвийн 200,000,000.0 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7 сумын **20 мянган га** бэлчээрийн талбайд 40 тонн бактержуулсан бэлдмэлийг цацав.

Аймгийн хэмжээнд 20 мянган га талбайд тэмцэх ажлыг зохион байгуулахад нийт 7 сумын 22 багийн нутагт 219 хүн нийт 22 авто машин, 3 мотоцикол, дунджаар 6-14 хоногт ажиллалаа. Орон нутгийн сангаас-2831800 төгрөгийг шатахууны зардалд, бусад зардалд-1676000 төгрөг /хоол хүнс, хөдөлмөр хамгаалал /гэх мэт, хөдөлмөр халамж үйлчилгээний газраас-9800000 төгрөгийг зарцуулж тэмцэх арга хэмжээнд нийт 14307800 төгрөгний зардлыг гаргаж үр дүнтэй зохион байгууллаа.

2021 онд микробиологийн аргаар тэмцсэн талбайн хэмжээ, бэлдмэлийн хэмжээ

| д/д | Сумдын нэр | Үлийн цагаан оготно тархсан талбай мянган/га | Тэмцэх талбайн хэмжээ мянган /га / | Бэлдмэлийн хэмжээ / тн / | Шуудай /ш/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Адаацаг | 89020 | 5.0 | 10 | 285 |
| 7 | Говь-Угтаал | 5800 | 2.0 | 4 | 114 |
| 2 | Дэлгэрцогт | 15256 | 3.0 | 6 | 171 |
| 3 | Дэрэн | 173400 | 3.0 | 6 | 171 |
| 4 | Цагаандэлгэр | 100000 | 3.0 | 6 | 171 |
| 5 | Сайнцагаан | 150000 | 2.0 | 4 | 118 |
| 6 | Сайхан-Овоо | 126000 | 2.0 | 4 | 114 |
| | Нийт | 659476 | **20.0** | 40 | 1144 |

## ДУНДГОВЬ АЙМГИЙН 2021-2022 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БАЙДАЛ

2020 оны 11 дүгээр сард ихэнх нутгаар олон жилийн дундажаас ахиу хур тунадас унасан бөгөөд Цагаандэлгэр, Луус сумдаар ОЖДундажын орчим хур тунадас унасан. 2020 оны 12 дугаар сард нийт нутгаар олон жилийн дундажаас бага хур тунадас унасан бөгөөд Цагаандэлгэрт ОЖДундажаас ахиу хур тунадас унасан. 2021 оны 1 дүгээр сард Говь-Угтаал суманд олон жилийн дунджаас ахиу, Цагаандэлгэрт олон жилийн дунджийн орчим, бусад ихэнх нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас орсон.

Цасан бүрхүүлийн хувьд 2020 оны 11 сарын 30-ны байдлаар Мандалговь, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил, Хулд сумдад 1 – 4 см зузаантай, 0,09 – 0,27 гр/см$^3$ нягттай, битүү 10 баллын бага зэрэг хунгарласан сэвсгэр цастай, бусад нутгаар 0 – 2 см зузаантай 5 – 9 баллын цасан бүрхүүл тогтсон.

2021 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн байдлаар Цагаандэлгэр сум 4 см зузаантай 10 баллын мөстсөн цастай Мандалговь, Эрдэнэдалай, Адаацаг, Говь-Угтаал, Дэрэн сумдад 1-2 см зузаантай, 5-9 баллын мөстсөн цастай, Гурвансайхан, Баянжаргалан, Өндөршил, Сайхан-Овоо, Луус, Дэлгэрхангай сумдад 1-4  баллын мөстсөн цастай, нийт нутгийн 60 хувь нь цасан бүрхүүлтэй, үүнээс хамгийн их цастай нутаг Эрдэнэдалай, Адаацаг, Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал сум, Сайнцагаан, Дэрэн, Дэлгэрцогт, бусад нутгаар бага зэргийн цасан бүрхүүлтэй, Луус, Хулд, Дэлгэрхангай, Өлзийт сумд цасгүй. 2021 оны 2 дугаар сард нийт нутгаар цасгүй болсон(Зураг 1).

2020 - 2021 оны өвөл тус аймагт бага зэргийн цастай, 12, 1 сард хүйтэн, цастай байсан, 2 дугаар сарын эхний арав хоногт бага зэрэг хүйтэрсэн, Дундговь аймгийн нэлээд малчид өөр аймагруу отороор явсан, нутагтаа байгаа малчид өвөлжөөндөө, бод, бог малд нэмэгдэл тэжээл өгөх, хужир шүү татах  зэрэг ажил  явагдахад 2 - 24 хоног 30 – 38 градус хүрч хүйтэрч цасан шуургатай, цаг агаар тааламжгүй хүйтэн жиндүү байсан.




**2020 оны 11-р сар 30-нд**  **2020 оны 12-р сар 31-нд**  **2021 оны 01-р сарын 31-ны байдлаар**

Зураг 1. Цасан бүрхэц MODIS хиймэл дагуулаас авсан

2021 оны 11 сард хур тунадас Говь-Угтаалд олон жилийн дунджаас ахиу, Өндөршилд олон жилийн дунджийн орчим, бусад ихэнх нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас орсон. 2021 оны 12 сард тунадасны хувьд Цагаандэлгэрт олон жилийн

дунджаас ахиу, Сайхан-Овоо, Говь-Угтаал, Өндөршил сумдад олон жилийн дунджийн орчим, бусад ихэнх нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас орсон. 2022 оны 1 сард **х**ур тунадас Дэрэнд, Говь-Угтаал, Луус, Өндөршил, Хулд суманд олон жилийн дунджаас ахиу, Адаацаг, Цагаандэлгэрт олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас орсон.

Цасан бүрхүүлийн хувьд 2021 оны 11 сарын 30-ны байдлаар Адаацаг, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдад 1 – 4 баллын бага цасан бүрхүүлтэй, бусад нутгаар цасгүй байна. Цасан бүрхүүлийн хувьд Сайхан-Овоо, Цагаандэлгэр сумдад 1 см зузаантай 5 - 9 баллын мөстсөн цастай, Эрдэнэдалай, Адаацаг, Дэрэн, Баянжаргалан сумдад 1 – 4 баллын цастай, бусад нутгаар цасан бүрхүүл тогтоогүй.

2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар Сайхан-Овоо, Цагаандэлгэр сумдад 1 см зузаантай 5 - 9 баллын мөстсөн цастай, Эрдэнэдалай, Адаацаг, Дэрэн, Баянжаргалан сумдад 1 – 4 баллын цастай, бусад нутгаар цасан бүрхүүл тогтоогүй.

2022 оны 1 сарын 31-ны өдрийн байдлаар Цагаандэлгэр суманд 2 см зузаантай, 10 баллын сэвсгэр цастай, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумдад 1-4 баллын мөстсөн цастай, бусад нутгаар 0 - 2 см зузаантай 5-9 баллын мөстсөн цасан бүрхүүл тогтоод байна.

2022 оны 2 сарын 28-ны өдрийн байдлаар Цагаандэлгэр, Дэлгэрхангай сумдад 0 -1 см зузаантай 5 - 9 баллын цастай, бусад нутгаар 1-4 баллын мөстсөн цастай, Эрдэнэдалай, Гурвансайхан, Баянжаргалан, Өлзийт, Өндөршил сумдын нутгаар цасгүй байсан(Зураг 2).




**2021 оны 12-р сар 31-нд** **2022 оны 1-р сар 31-нд** **2022 оны 2-р сарын 28-ны байдлаар**

Зураг 2. Цасан бүрхэц MODIS хиймэл дагуулаас авсан

2021-2022 оны өвөлжилтын байдал Дундговь аймагт цас багатай өнтэй өвөл болсон, нутгийн малчид нутагтаа өвөлжсөн, харин хил залгаа нутгийн аймгуудаас малчид ирж отороор өвөлжсөн.






## Дундговь аймгийн 2021-2022 оны бэлчээрийн ургамлын ургалт, зуншлагын байдал

2021, 2022 оны зуншалгыг харьцуулахад 2021 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар Гурвансайхан, Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Луус, Өндөршил сумдад ургамал дөнгөж цухуйсан, мал ногоонд цадах боломжгүй нийт нутгийн 45 хувьд ургамал цухуйсан, 55 хувьд ургамал цухуйгаагүй. 2022 4 дүгээр сарын 30-ны байдлаар ихэнх нутгаар ургамал цухуйсан, Сайхан-Овоо суманд ургамал цухуйгаагүй. Ургамлын дундаж өндөр 1 – 2 см, мал ногоонд цадах боломжгүй байна(Зураг1).

2021 оны 5 дугаар сарын 31-ны ургамлын өндөр дунджаар 0 - 6 см, ургамлын ургалтын байдал Сайхан-Овоогийн зүүн тал, Адаацагийн хойд тал, Эрдэнэдалай, Цагаандэлгэр сумдад дунд зэрэг буюу нийт нутгийн 20 орчим хувь, бусад нутгаар ургамлын ургалт муу байна. 2022 оны 5 дугаар сарын 31-ны байдлаар бэлчээрийн ургамал таана, хазаар хялгана цухуйсан боловч салхи ихтэй, шөнөдөө сэрүүн хонож байгаагаас ургалт удааширалтай, үзүүрээсээ хатаж гэмтсэн ургамлын өндөр дунджаар 1 - 8 см, ихэнх нутгаар ургац 0,0 – 0,3 ц/га, ургамлын ургалтын байдал Сайнцагааны хойд тал, Гурвансайхан, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өлзийт, Өндөршил сумдын нутгаар  дунд зэрэг буюу нийт нутгийн 45 орчим хувь, бусад нутгаар ургамлын ургалт муу байна(Зураг 1).

2021 оны 8 дугаар сарын 31-ны бэлчээрийн ургамлын өндөр дунджаар 5 - 14 см, ургац 0,1 – 4,2 ц/га, ургамлын ургалтын байдал Сайхан-Овоогийн баруун, хойд, зүүн тал, Хулдын баруун, зүүн тал, Эрдэнэдалай, Адаацагийн баруун, хойд тал, Дэлгэрхангайн баруун талын нутгаар сайн, буюу нийт нутгийн 20 орчим хувь хэвийн,  Баянжаргалангийн хойд, урд талын нутгаар муу буюу 5 орчим хувь,  бусад нутгаар дунд зэрэг буюу нийт нутгийн 75 хувь нь байна. 2022 оны 8 дугаар сарын 31-ны байдлаар ургамлын өндөр дунджаар 3 - 21 см, ургац 0,0 – 3,0 ц/га, ургамлын ургалтын байдал Сайнцагааны хойд тал, Адаацаг, Дэрэн, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдын нутгаар сайн буюу нийт нутгийн 30 хувь, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Хулд сумын баруун, зүүн, урд тал муу буюу нийт нутгийн 20 хувь нь, бусад нутгаар  дунд зэрэг буюу нийт нутгийн 50 хувь нь байна(Зураг 1).




2021 оны 4-р сарын 30-ны байдлаар        2022 оны 4-р сарын 30-ны байдлаар






2021 оны 5-р сарын 31-ны байдлаар 2022 оны 5-р сарын 31-ны байдлаар






2021 оны 8-р сарын 31-ны байдлаар 2022 оны 8-р сарын 31-ны байдлаар

Зураг 1. Бэлчээрийн ургамлын ургалтын байдал, балл
2021, 2022 оны 4,5, 8 дугаар сарын 31-ны байдлаар

2021 онд нийт нутгийн 20 хувьд, 2022 онд 30 хувьд зуншлага сайн байсан бол 2021 онд Баянжаргалан сумын хойд, урд зүг муу буюу гантай, 2022 онд аймгийн баруун, баруун урд зүгийн нутаг Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Хулд сумын баруун, зүүн, урд тал муу буюу нийт нутгийн 20 хувь гантай, бусад нутгаар 2021 онд 75 хувьд, 2022 онд 50 хувьд дунд зэрэг буюу гандуу байжээ.

## 2021-2022, 2022-2023 ОНЫ ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨВӨЛ, ХАВРЫН БЭЛЧЭЭРИЙН ДААЦЫГ ТОДОРХОЙЛСОН ДҮН

Монгол улсын Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2021-2022, 2022-2023 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн багийн нутгаар тооцоолж гаргав.

Дундговь аймгийн хэмжээгээр авч үзвэл: Зуншлагын байдал 2021 оны 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 20 хувьд хэвийн, 75 гаруй хувьд дунд зэргийн зуншлагатай, 5 орчим хувьд муу байна. Зуншлагын байдал 2022 оны 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 30 хувьд хэвийн, 50 гаруй хувьд дунд зэргийн зуншлагатай, 20 хувьд муу байна.

Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл: Аймгийн нийт багуудын нутгаар бэлчээрийн даацын хэмжээг тодорхойлсон байдлаар гаргахад(2021-2022 он).
**10 % нь 50 хүртэлх хувь (бэлчээрийн нөөцтэй)**
**16 % нь 51-100 хувь (бэлчээр хүрэлцээтэй)**
**46 % нь 101-300 хувь (даац 1-3 дахин хэтэрсэн)**
**8 % нь 301-500 хувь (даац 3-5 дахин хэтэрсэн)**
**20 % нь 500 хувиас их (даац олон дахин хэтэрсэн)** байдалтай гарсан байна.

Өөрөөр хэлбэл аймгийн дүнгээр нутгийн 26 хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байх боломжтой. Харин нутгийн 46 хувь нь 1-3 дахин хэтэрсэн, 8 хувь нь 3-5 дахин хэтэрсэн, 20 хувь бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн өөрөөр хэлбэл нийт нутгийн 74 хувьд бэлчээрийн даац 3 буюу түүнээс дээш олон дахин хэтэрч гарсан.

Бэлчээрийн даац **олон дахин хэтэрч** (улаан) гарсан сум, багуудад Эрдэнэдалай сумын Рашаант баг, Баянжаргалан сумын Энгэр ус баг, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил сумдын багын нутаг орж байна.

Мөн Сайнцагаан сумын Тэвш, Үйзэн багууд, Дэрэн сумын Бумбат баг, Баянжаргалан сумын Шилийн гол баг **даац 3-5 дахин** (улбар шар) хэтэрч гарсан байна.

Сайхан-Овоо сумын Төгрөг, Найз баг, Дэлгэрхангай сумын Ар шавагтай баг, Эрдэнэдалайн Цавчир, Сангийн далай, Цагаан овоо багууд, Луус сум, Адаацагийн Ар-Урт, Өвөр-Урт баг, Хулд сумын Уул, Шувуутай баг, Сайнцагаан сумын Наран, Далай баг, Дэлгэрцогтын Дэлгэр-Эмт баг, Дэрэнгийн Саруул, Исгэлэн баг, Гурвансайхан сумын Чулуут, Элгэн, Гурвансайхан баг, Өлзийтийн Дэрт-1, Дэрт-2, Буянт-1, Буянт-2 багын нутаг **даац 1-3 дахин хэтэрсэн** тул мал өвөлжилт, хаваржилтын нөхцөл хүндэрч болзошгүй (Бэлчээрийн даацын зураг) байна.




Энэ жил ихэнх нутагт зуншлага оройтсон ба бороо их орсон газраар лууль, шарилж зэрэг нэг наст ургамлууд, таана, хөмүүл зонхилсон. Гэхдээ эдгээр ургамлууд өвөл хавартаа бэлчээрт хадгалагдаж үлдэхгүй онцлогтой мөн мал тарга тэвээрэг бүрэн авч чадаагүй зэрэг онцлог нөхцөл үүсээд байгааг харгалзан үзэх нь чухал юм.

Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл: Аймгийн нийт багуудын нутгаар бэлчээрийн даацын хэмжээг тодорхойлсон байдлаар гаргахад(2022-2023 он).
**23 % нь 50 хүртэлх хувь (бэлчээрийн нөөцтэй)**
**27 % нь 51-100 хувь (бэлчээр хүрэлцээтэй)**
**37 % нь 101-300 хувь (даац 1-3 дахин хэтэрсэн)**
**5 % нь 301-500 хувь (даац 3-5 дахин хэтэрсэн)**
**8 % нь 500 хувиас их (даац олон дахин хэтэрсэн)** байдалтай гарсан байна.

Өөрөөр хэлбэл аймгийн дүнгээр нутгийн 50 хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байх боломжтой. Харин нутгийн 37 хувь нь 1-3 дахин хэтэрсэн, 5 хувь нь 3-5 дахин хэтэрсэн, 8 хувь бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн өөрөөр хэлбэл нийт нутгийн 50 хувьд бэлчээрийн даац 3 буюу түүнээс дээш олон дахин хэтэрч гарсан.

Бэлчээрийн даац олон дахин хэтэрч (улаан) гарсан сум, багуудад Эрдэнэдалай сумын Өнгөт, Сангийн далай багууд, Сайхан-Овоо сумын Мааньт, Найз, Төгрөг багийн нутаг орж байна.

Мөн Сайхан-Овоо сумын Онги баг, Дэлгэрхангай сумын Номгон баг, Өндөршил сумын Талын нар баг даац 3-5 дахин (улбар шар) хэтэрч гарсан байна.

Эрдэнэдалайн Цавчир, Тэнгэлэг, Рашаант, Цагаан овоо багууд, Хулд, Говь-Угтаал сумд, Сайнцагаан сумын Наран, Далай, Үйзэн багууд, Өлзийтийн Тагт, Буянт-2 багууд, Өндөршил сумын Цог багийн нутаг, даац 1-3 дахин хэтэрсэн тул мал өвөлжилт, хаваржилтын нөхцөл хүндэрч болзошгүй (Бэлчээрийн даацын зураг) байна.




Энэ жил ихэнх нутагт зуншлага хэвийн ба бороо их орсон газраар лууль, шарилж зэрэг нэг наст ургамлууд, таана, хөмүүл зонхилсон. Гэхдээ эдгээр ургамлууд өвөл хавартаа бэлчээрт хадгалагдаж үлдэхгүй онцлогтой мөн мал тарга тэвээрэг бүрэн авч чадахгүй байх зэрэг онцлог нөхцөл үүсээд байгааг харгалзан үзэх нь чухал юм.

Тайлан бичсэн: ХААЦУ ЕТ инженер Б.Болортуяа

## 2.4. УУЛ УУРХАЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2021 онд нийт 8 сумын нутаг дэвсгэрт 33 талбар бүхий газарт 33.51 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн бөгөөд дэд бүтцийн улмаас эвдэрсэн талбайд 2.2 га, бичил уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн талбайд 12.52 га, уул уурхайн

олборлолтын улмаас эвдэрсэн газарт 3.9 га, хайгуулын улмаас эвдэрсэн талбайд 0.64 га, эзэнгүй эвдэрсэн газарт дүйцүүлэн хамгааллын хүрээнд 14.25 га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт, 4 сумын нутаг дэвсгэрт 5 аж ахуйн нэгж 5.1 га талбайд мод бут, олон наст ургамал тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэн биологийн нөхөн сэргээлт тус тус хийсэн.

2022 онд нийт 8 сумын нутаг дэвсгэрт 14 талбар бүхий газарт 35.76 га талбайд нөхөн сэргээлт хийсэн. Үүнд: Дэд бүтцийн улмаас эвдэрсэн 2.2 га, уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн 8.89 га, хайгуулын улмаас эвдэрсэн 0.12 га, эзэнгүй эвдэрсэн газарт дүйцүүлэн хамгааллын хүрээнд 10.01 га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт, 4 сумын нутаг дэвсгэрт 5 аж ахуйн нэгж 4.24 га талбайд мод бут, олон наст ургамал тарьж, Дэлгэрцогт суманд хууль бусаар байгалийн өнгөт чулуу олборлосны улмаас эвдэрсэн газрын тооллогоор 14.54 га талбай байгалийн аясаар нөхөн сэргээгдсэн нь тогтоогдсон.

| № | Нөхөн сэргээлтийн төрөл | Төлөвлөсөн Хэмжээ | 2021 | 2022 | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| 1 | Техникийн | 20 га | 33.61 га | 16.92 га | -16.69 |
| 2 | Биологийн | 5 га | 5 га | 18.84 га | +13.84 |
| | Нийт | | **38.61 га** | **35.76 га** | **+2.85** |

Дундговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (2021-2024), Аймгийн стратеги төлөвлөгөөнд жил бүр 20 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. 2022 онд биологийн нөхөн сэргээлт 3.7 дахин нэмэгдсэн бол техникийн нөхөн сэргээлт төлөвлөсөн хэмжээндээ хүрээгүй байна.

## 2.4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮНЭЛГЭЭ

БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу дэд бүтэц, үйлчилгээний 14, хайгуулын 33, ашиглалтын 13, нийт 60 төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хүлээн авч бүртгэн, хяналт тавьж ажиллалаа.

 

### 2.4.1.1 БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Орон нутагт хэрэгжиж буй үйлдвэрлэл, үйлчилгээ, болон бусад салбарын төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд холбогдох журмын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн.

2021 онд тус аймгийн 8 суманд хэрэгжих дэд бүтэц, хөдөө аж ахуйн, худалдаа үйлчилгээний 12 аж ахуйн нэгж, 11 иргэний нийт 26 төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ. Ерөнхий үнэлгээ шууд буюу нөхцөл болзолтой хэрэгжүүлэхээр дүгнэлтүүд гаргав.

2022 онд тус аймгийн 6 суманд хэрэгжих дэд бүтэц, худалдаа үйлчилгээний 17 аж ахуйн нэгж, 12 иргэний нийт 29 төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ. Ерөнхий үнэлгээ шууд буюу нөхцөл болзолтой хэрэгжүүлэхээр дүгнэлтүүд гарган хуулийн хугацаанд хүргүүлэв.

***Уул уурхайн ашиглалт, хайгуулын мэдээллийн сан***




2022 оны байдлаар Дундговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 118, хайгуулын тусгай зөвшөөрөл 132 нийт 250 тусгай зөвшөөрөл байна.

***Тусгай зөвшөөрөл эзэмшигчид сумдаар***



Уул уурхайн үйл ажиллагаа их идэвхтэй
Уул уурхайн үйл ажиллагаа дунд зэрэг идэвхтэй
Уул уурхайн үйл ажиллагаа бага зэрэг идэвхтэй
Уул уурхайн үйл ажиллагаа идэвхгүй сумд
Бичил уурхайн үйл ажиллагаатай сумд
Давхар бичил уурхайтай
Байгалийн өнгөт чулууны олборлолтод өртсөн

## 4.2 ЭВДЭРСЭН ГАЗРЫН ТООЛЛОГО

Дундговь аймгийн хууль бус ашигт малтмалын улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон газрын хэмжээг тодорхойлох зорилгоор "Эко Ти Эс Би" ХХК-тай гэрээ байгуулан ажлын даалгаврын дагуу гүйцэтгүүлсэн ба газарзүйн мэдээллийн системийн Arcgis 10.5, Photoscan зэрэг програм хангамжуудыг ашиглан хийж гүйцэтгүүлсэн.

***Тооллого хийсэн газрын байршил***




Судалгааны ажлын хүрээнд Дундговь аймгийн Сайхан овоо, Хулд, Луус, Дэлгэрцогт, Сайнцагаан, Өлзийт гэсэн 6 сумын хэмжээнд нийт 13 эвдэрсэн газрын судалгааг хийсэн ба нийт эвдэрсэн талбайн хэмжээ нь 75.4 га талбай байна.

## 2.5. УСНЫ НӨӨЦ

**2.5.1. Гадаргын ус.** Аймгийн хэмжээнд гадаргын ус буюу булаг, шанд, нуур тойром 2022 оны жилийн эцсийн байдлаар 170 байна. Гадаргын усны нөөц нь 0.12км$^3$ байна. Сүүлийн 5-10 жилд 40 гаруй булаг шанд, нуур ширгээд байна. 2021 онд 5 гадаргын эх үүсвэр хатаж ширгэсэн. Гадаргын усны хатаж, ширгэсэн болон сэргэсэн эх үүсвэрийг сумдаар нь авч үзвэл 2021 онд Өндөршилд 4, Сайхан-Овоо суманд 1 ширгэсэн булаг шанд, нуур ширгэсэн байна. Аймгийн хэмжээнд жилд дунджаар 4-5 гадаргын усны эх үүсвэр хатаж ширгэдэг. 2022 онд хатаж ширгэсэн гадаргын эх үүсвэр байхгүй.

**Онгийн гол.** Хангайн нурууны зүүн өвөр хажуугийн далайн түвшнээс 2570 м өндөрт орших Ногоон нуураас эх авч Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутаг дахь Улаан нуурт цутгах 403 км урт гол 54 км нь Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумын нутгийг дамжина. Гандуу жил Дэлгэрхангай сумын нутаг дахь Хошуу хурлын хүрээ хавьд сэвсгэр хөрсөнд шургана. Хуртайд усны түвшин дээшилж урсгалын хурд нэмэгдэж адагтаа хүрнэ. 11-р сард хөлдөж дараа жилийн 4-р сард гэснэ. Бараг харзлахгүй. Хөвөө гольдролын хөндийд дэрс харгана элбэг бий. Усны химийн найрлага нь гидрокарбонатын бүлэгт багтана. Говь руу очдог гуравхан голын нэг Онгийн гол Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгийн сумын нутгийг дамжин хүн, малын ундаа болсоор ирсэн.



*Гэрэл зургийг: Э.Бат-Амьдрал*

Онги голын усны төлөв байдлын мэдээлэл
2021 он

Түвшний хэмжилт хийсэн хоногоор тооцож дунджийг тооцвол 99 см буюу гол тасралт ихтэй усны түвшин маш бага байсан.

2022 он

Жилийн түвшин хэмжигдсэнээр тооцсон дундаж 101 см буюу гол тасралт ихтэй усны түвшин маш бага байсан.

2021 оны 04-р сарын 23-ны байдлаар: Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутгаар урсдаг онги голын усны түвшин 111 см

**2.5.2. Газрын доорх усны нөөц**

Газрын доорх усны нөөц нь 0.08 км$^3$ байна. Газрын доорх уст цэгийн тоо 3791 болоод байна.

**2.5.3. Усны нөөцийн хамгаалалт**

Одоогийн байдлаар нийт 121 булгаас 59 булгийн эхийг хашиж хамгаалаад байна.

2008 оноос эхлэн булгийн эхийг хашиж хамгаалах ажил улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байсан ч сүүлийн жилүүдэд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал буюу орон нутгийн төсвийн хөрөнгөөр жил бүр булгийн эхийг хаших хамгаалах ажлыг гүйцэтгэдэг. Аймгийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээнд жил бүр булгийг эхийг хашиж хамгаалах ажлыг тусган хэрэгжүүлдэг.





Булгийн эхийг хашиж тохижуулсан байдал 2008-2022




| | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Улсын төсөв | 7 | 3 | 7 | 9 | 4 | 0 | 2 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| орон нутгийн төсөв | 0 | 0 | 0 | 0 | 0 | 4 | 0 | 1 | 3 | 3 | 4 | 3 | 3 | 3 |
| төслийн хөрөнгө оруулалт, хувийн хэвшил | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 1 | 0 | 0 |

Улсын төсөв　орон нутгийн төсөв　төслийн хөрөнгө оруулалт, хувийн хэвшил




**<u>ХӨВ ЦӨӨРӨМ БАЙГУУЛАВ</u>**

2022 онд Өлзийт сумын Буянт багийн нутаг “Жавхлант хайрхан” хэмээх газарт байрлах “Хөтөл ус”-ны энгийн уурхайн худгийг түшиглэн Улсын төсвийн хөрөнгөөр хөв цөөрөм байгууллаа.

Мөн Юнител группийн хөрөнгө оруулалтаар "Дэлгэрхангай уул", "Их газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газруудад зэрлэг амьтдад зориулсан хөв цөөрмийг байгуулав. 2021 онд хөв цөөрөм байгуулах ажил хийгдээгүй, 2022 онд 3 нийт хөв цөөрөм байгуулав.









**<u>ТӨВ СУУРИН ГАЗРЫН УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРТ ЦЭВЭРШҮҮЛЭХ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАВ</u>**

Дундговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2021-2024/, Аймгийн стратеги төлөвлөгөө /2021-2024/-нд тусгагдсанаар цэвэршүүлэх төхөөрөмжийг үе шаттай суурилуулж байна. Дундговь аймгийн Баянжаргалан суманд орон нутгийн төсвийн хөрөнгөөр төвийн

ундны усны 1 эх үүсвэрт, 2022 онд Дэлгэрхангай суманд орон нутгийн хөгжлийн сангийн 20 сая төгрөгийн хөрөнгөөр 2 тн нөөцийн савтай цэвэршүүлэх төхөөрөмжийг сумын төвийн ундны усны 2 эх үүсвэр дээр суурилуулав. Цэвэршүүлэх төхөөрөмж болон ус цэвэршүүлэгч суурилуулах ажлыг орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэв. 2022 оны байдлаар 2 сумын төвийн 3 ундны эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулснаар төв суурин газрын цэвэршүүлсэн усаар хангагдсан хүн амын тоо 34%-иар нэмэгдлээ.

Усны нэгдсэн тооллогыг 5 жилд нэг удаа хийдэг. 2020 онд Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаатай усны нэгдсэн тоо бүртгэл явуулах ажил гүйцэтгэх гэрээ байгуулж тооллогын ажлыг хийж гүйцэтгэлээ. Тооллогоор 3507 худаг, 117 булаг, 18 нуур, 1 рашаан тоологдлоо. 2016 оноос хойш 169 өрөмдмөл худаг шинээр гаргаж, 6 булаг сэргэсэн байна. Усны тооллого 2024 онд хийгдэх болно.

## УСНЫ НӨӨЦИЙН АШИГЛАЛТ

Усны тухай хуулийн дагуу 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны газар гаргаж байна.

*__Ус ашиглуулах дүгнэлт гаргуулсан аж ахуйн нэгж, иргэдийн тоо, хэрэглэсэн ашигласан усны хэмжээг харуулбал:__*

| **Он** | **Аж ахуйн нэгж, байгууллагын тоо** | **Ашиглаж байгаа усны эх үүсвэр** | **Нийт ашиглах усны хэмжээ м$^3$/жилд** | **Төлбөр ногдуулсан усны хэмжээ м$^3$/жилд** | **Усны нөөц ашигласны төлбөр төг** |
|---|---|---|---|---|---|
| 2019 | 46 | Газрын доорх ус | **65940,13** | **54625,9** | **28.100.088** |
| 2020 | 16 | Газрын доорх ус | 20.917.65 | 18263 | 16.325.010 |
| 2021 | 42 | Газрын доорх ус | 185.260.607 | 17.427.265 | 27.802.189 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2022 | 17 | Газрын доорх ус | 20.384.632 | 1.290.463 | 13.378.436 |

Байгаль орчны захиргааны статистик маягтийн судалгаагаар

Энэ нь нийт газрын доорх усны нөөцийн 6.31%-ийг эзэлж байна. 2021 онд нийт ашигласан усны хэмжээ 9.7 сая м$^3$, хүн амын унд ахуйн хэрэгцээнд 0.9 сая м$^3$, үйлдвэрлэлд 8.8 сая м$^3$, 2022 онд нийт ашигласан усны хэмжээ 7492730 м$^3$ байна. Үүнээс хүн амын унд ахуйн хэрэглээнд 451800 м$^3$, үйлдвэрлэлд 7029190 м$^3$ тус тус ашигласан байна.

Усны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэхь заалтын дагуу иргэн, ААН-д худаг гаргах зөвшөөрлийг олгон ажиллаж байна. 2020 онд аймгийн хэмжээнд нийт 5 суманд 23 гүн өрмийн худгийг шинээр 534 сая төгрөгөөр,

Аймгийн хэмжээнд иргэдэд унд ахуйн зориулалтаар 60 өрөмдмөл худгаас ус түгээж байна. Үүний 14 сумын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоосон.

## 2.6. ОЙН НӨӨЦ, ОЙН НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

### 2.6.1. ОЙН НӨӨЦ

Ойн сангийн газарт байгалийн болон таримал ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавьж өвчинд нэрвэгдсэн ойн талбай, түүнчлэн ойн захаас гадагш 100 метр хүртэлх газар, тарьц суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай тус тус хамаарна.

Дундговь аймгийн Өлзийт сумын 32759 га заган ой бүхий талбай нь ойн сан бүхий газарт хамаарч, тус ойн сангийн 20683 га талбай нь Загийн усны байгалийн нөөц газарт хамаарч улсын тусгай хамгаалалттай газарт ордог.

Дундговь аймагт ойн зохион байгуулалтын ажлыг мэргэжлийн байгууллага 2 удаа хийж гүйцэтгэсэн.

- 2007 онд ойн зохион байгуулалтын ажлаар 58 мянган га талбай ойн сангийн нөөцтэй.

/Ой хайгуул судалгааны төв/

- 2015 онд 32759 га талбай ойн сангийн нөөцтэй гэж тоологдсон. / “Денс форист” ХХК/ зөрүү 25255

**О**йн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай 13075 га талбайгаар, ойгоор бүрхэгдээгүй талбай 12169 га талбайгаар тус тус багасаж гарснаар ойн талбайн дүн нийтдээ 25255 га талбайгаар багасаж гарсан үзүүлэлттэй байна.

| **Ойн сангийн талбай** | **Газрын төрөл** | **2015 он** | **2007 он** | **Зөрүү** |
|---|---|---|---|---|
| Ойгоор бүрхэгдсэн | Байгалийн ой /заг/ | 16793 | 19187 | -2394 |
| | Бут, сөөг /сухай/ | 16 | 10751 | -10735 |
| | Таримал | 43 | | 43 |
| | Дүн | 16852 | 29938 | -13086 |
| Ойгоор бүрхэгдээгүй | Тармаг | 14953 | 28028 | -13075 |
| | Ойжих | 954 | | 954 |
| | Ойжуулсан | | 48 | -48 |
| | Дүн | 15907 | 28076 | -12169 |
| | Нийт дүн | 32759 | 58014 | -25255 |




Говийн бүс нь цаг уурын хатуу ширүүн нөхцөлтэй тул ургамлын төрөл зүйл цөөн, заг болон модлог ургамал тачир сийрэг ургах тул ойн сангийн газрын төрөл цөөн байна. Өлзийт сумын заган ойн сангийн талбайг газрын төрлөөр ангилан хэсэглэл тус бүрээр гаргаж харуулбал:

**Ойн сангийн талбайн газрын төрлийн ангилал**

| Хэсэглэл | Ойгоор бүрхэгдсэн | | | | Ойгоор бүрхэгдээгүй | | | Ойн талбайн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байгалийн ой | Сөөг | Таримал ой | Дүн | Тармаг мод | Ойжих талбай | Дүн | |
| **Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүсийн ой – Байгалийн нөөц газар** | | | | | | | | |
| **2** | 2326 | 6 | 43 | 2375 | 3784 | | 3784 | 6159 |
| **4** | 3511 | 3 | | 3514 | 1341 | 954 | 2295 | 5809 |
| **5** | 5312 | | | 5312 | 3403 | | 3403 | 8715 |
| **дүн** | 11149 | 9 | 43 | 11201 | 8528 | 954 | 9482 | 20683 |
| **Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүсийн ой – Орон нутгийн тусгай хамгаалалттай газар** | | | | | | | | |
| **1** | 2982 | | | 2982 | 4069 | | 4069 | 7051 |
| **3** | 2662 | 7 | | 2669 | 2356 | | 2356 | 5025 |
| **дүн** | 5644 | 7 | | 5651 | 6425 | | 6425 | 12076 |
| **Нийт дүн** | 16793 | 16 | 43 | 16852 | 14953 | 954 | 15907 | 32759 |

Өлзийт сумын заган ойн сангийн нийт талбай 32759 га талбай байгаагаас 16852 га буюу 51.4% нь ойгоор бүрхэгдсэн талбай, 15907 га буюу 48.6% нь ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлж байна. Ойгоор бүрхэгдсэн талбайн 16793 га буюу 99.64%-ийг байгалийн заган ой 16 га буюу 0.09%-ийг сөөг (сухай), 43 га буюу 0.25%-ийг таримал заг, ойгоор бүрхэгдээгүй талбайн 14953 га буюу 94%-ийг тармаг заг, 954 га буюу 6%-ийг ойжих талбай тус тус эзэлж байна.

Ойн сангийн талбайг сумын нийт газар нутагтай харьцуулбал 2.1%-ийг ойн сан бүхий талбай эзэлж байна. Өлзийт сумын байгалийн ойг бүрдүүлэгч гол мод нь заг бөгөөд сухай бага хувийг эзэлж байна. Дэлхий нийтийг хамарсан байгаль цаг уурын дулааралтай холбоотойгоор жилд орох хур тунадасны хэмжээ багассанаас заган ой хатаж хуурайшин сийрэгжихийн зэрэгцээ загийн салмаа нь мал амьтны чухал тэжээлийн нэг болдог тул шинэ залуу загийн өсвөр ургац, загийн салмааг идэж сүйтгэн түүний нөхөн сэргэх явцад саад учруулдаг.

### 2.6.2. Ойн нөөцийн хамгаалалт

Өлзийт сумын заган ойн сангийн 20683 га талбайг багтаан нийтдээ 273571 га талбайг "Загийн усны байгалийн нөөц газар"-ыг УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авчээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу тус байгалийн нөөц газарт байгаль хамгаалагч 2007 оноос хойш томилон ажиллуулж байна. Үүнээс өмнө хамгаалалтыг Өлзийт сум хариуцаж байв.

Загийн усны байгалийн нөөц газар нь Загийн усны хоолой дагуух газрыг хамрах ба хоолой дагуудаа хужир мараа, шал тойром, заган ой, довцог, элсэн манхан хослон орших учраас ландшафтын олон хэв шинж бүхий экологийн өвөрмөц орчныг үүсгэдэг. Загийн усны байгалийн нөөц газар нь заган ойн тархалтын зүүн талын хамгийн хойт цэг болдог ба хамгийн залуу, нөхөн ургалт сайтай хэдий ч аж ахуйн хэрэгцээнд зориулан түүх, устгах явдал мэр сэр байгааг харгалзан загийг хамгаалах, нөхөн ургах нөхцлийг бүрдүүлэх, зүй зохистой ашиглах зорилгоор байгалийн нөөц газар болгожээ. Монгол орны хар сүүлт зээрийн тархалтын хамгийн хойд, цагаан зээрийн тархалтын баруун хязгаар нутаг юм.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар модлог, бутлаг /бут, шаваг, заг, загасгал/ ургамлыг хамгаалах, түлшинд хэрэглэхгүй байх тогтоолыг 2008 онд гарган мөрдөж байна.

### 2.6.3. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт

***Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар*** 2021 онд улсын чанартай авто зам дагуу 25 га талбайд 15000 мод сөөг тарьж хамгаалалтын зурвас байгуулсан. 2022 онд Эрдэнэдалай сумын төвд 8 га талбайд 6300 мод тарьж ойн зурвас тус тус байгуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2005-2022 онд 12 суманд 177,4 га талбайд 97094 мод сөөг тарьж ургалтын хувь 80.8%-тай ургав.

***Орон нутгийн төсвөөр*** Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2021, 2022 онд 6 суманд 10 га талбайд ойн зурвас байгуулснаар 2009-2020 онд 12 суманд 120 га талбайд 67630 ширхэг мод сөөг тарьж 79.8 хувьтай ургав.

Аймгийн хэмжээнд сүүлийн 10 жилд улс, орон нутгийн төсөв болон гадаадын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр нийтдээ 412.4 га талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлээд байна.




| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| модны тоо | 17649 | 16650 | 13845 | 62670 | 122884 |
| ААНБ | 95 | 100 | 106 | 246 | 147 |
| Иргэн | 1518 | 1797 | 1810 | 3274 | 5690 |
| Өрх | 121 | 114 | 271 | 659 | 1053 |

***Бусад эх үүсвэрээс.*** БНСУ-ын Гуяан хот, Мандалговь хот 2009 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, 10 жилийн хугацаанд 100 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг эхлүүлсэн. 2009-2019 оны байдлаар 100 га-д 100000 мод тарьж, ургалтын хувь 75%-тай байна. Хамтын ажиллагааны хүрээнд Мандалговь хотын ЕБСургуулиуд, ААНэгж, байгууллагын албан хаагчид жил бүр ойжуулалтын бэлтгэл ажилд оролцож байна.


2018 고양의 숲 조성구역
1
2
3
4
5
6
7
8
9
만달고비




### 2.6.4. АЯН, ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД.

**“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” аян.** 2010 оноос хойш Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулдаг. Дундговь аймгийн хувьд 2010-2022 оны хооронд 22 удаагийн Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээг Сайнцагаан, Луус, Гурвансайхан, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумдад зохион байгуулав. 2010-2022 онуудад аймгийн хэмжээнд “Бүх нийтээр мод тарих өдөр” арга хэмжээнд 1616 аж ахуйн нэгж байгууллагын 35506 иргэн нийт 355491 ширхэг мод тарьсан байна.

***8 түмэн мод орон нутгийн хөдөлгөөн.*** Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтаж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх агаар хөрсний бохирдлыг бууруулах, хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх, иргэн, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор “Дундговио ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд болон “8 ТҮМЭН МОД ТАРИХ” хөдөлгөөнийг 2021 онд аймгийн хэмжээнд өрнүүлж, албан байгууллага бүр 80 мод, айл өрх бүр 8 мод тарих уриалга гаргаж хавар, намрын “Мод тарих үндэсний өдөр”-өөр 485 өрх, 246 аж ахуйн нэгж, байгууллагын 3274 иргэн 62670 мод, сөөгийг тарьж 78 хувийн амьдралттай ургасан.



**Тэрбум мод үндэсний хөдөлгөөн**. Тус аймаг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөнд 2022 оны намар нэгдэж Мод тарих үндэсний өдрөөр нээлтийн арга хэмжээг албан ёсоор эхлүүлж нээлтэд орон нутгийн удирдлагууд төр, хувийн хэвшлийн албан хаагчид, иргэд оролцов.




Бүх нийтээр мод тарих өдрөөр тарьсан модны тоо
140000
120000
100000
80000
60000
40000
20000
0
10650
10955
16650
13845
62670
122884
2017
2018
2019
2020
2021
2022
тарьсан модны тоо




### 2.6.5. МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР

Дундговь аймгийн Сум дундын ойн ангиийн мод үржүүлгийн газар нь анх 2009 онд байгуулагдсан.



Тарьц, суулгац:

Дундговь аймгийн Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газар нь төлөвлөгөөний дагуу улаан сухайн мөчир 4000 ширхэгийг өөрийн талбайгаас 3000 ширхгийг Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутгаас, 9000 ширхэг улиасны мөчир, 3000 ширхэг бургасны мөчир Улаанбаатар хотоос нийт 19,000 ширхэг мөчир стандартын бэлтгэн тарилтад бэлтгэн нийлүүлэв.









Үр тарилт:

20x6 харьцаатай 5 хүлэмж, 50 метрийн урттай 5 шуудууны хөрс боловсруулалтын ажлыг хийж хөрсний үржил шимийг нэмэгдүүлэн жигд модны үр 4кг, хайлаас 30кг,  шар хуйас 3кг, агч-1кг, бүйлс 5кг, голт бор 0,5кг тус тус бэлтгэж, нийт 43.5кг үр, 19300 ширхэг мөчир тарьсан. Мөн чийгэн улаан өтийг үржүүлэн органик бордоо боловсруулан мод, сөөгний ургалтыг дэмжин ажиллав.





## 2.7. ДУНДГОВЬ АЙМГИЙН УРГАМЛЫН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Ургамлын нэгдсэн тооллого, судалгааг 2018 онд “Эко үйлчилгээ” ТББ-аар гүйцэтгүүлэв.

Дундговь аймгийн нутаг дэвсгэр нь ургамал-газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог болон Дундад Халхын хээрийн тойргийн заагт (Өлзийхутаг, 1985), ургамалжлын бүс, бүслүүрийн хувьд хуурай хээр ба цөлийн хээрийн шилжилтийн бүс болох цөлжүү хээрийн дэд бүсэд (Түвшинтогтох, 2014) оршино (Зураг 1, 2).




*Зураг 1. Монгол орны ургамал газарзүйн тойрог*




*Зураг 2. Дундговь аймгийн нутаг дэвсгэр*

Манай орны нутаг дэвсгэр байгалийн 6 бүс бүслүүрт хуваагдана (Зураг 3). Дундговь аймгийн хувьд нутаг дэвсгэр нь харгана бүхий жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-хялганат жинхэнэ хуурай хээрийн хэв шинжийг илэрхийлдэг.

Цөлөрхөг хээр нь тус аймгийн өмнөт хэсгийг эзэлж байна. Монгол өвс-хазаар өвс-таанат бүлгэмдэл гол төлөөлөгч болдог. Тусгаг бүрхэц нь 20 хувь, дэрсэн толботой, 100 $м^2$-д монгол өвс, хазаар өвс, таана, хөмөл, арзгар согсоот, торгомсог хэрээн хошуу, агь зэрэг 8-9 зүйл ургамалтай.

Дэрс, дэрст-бударганат хотгор хөндий нь Дундговь аймгийн нийт нутгаар алаг цоог тохиолдоно. Дэрс бүхий бударгана-таанат, дэрст, дэрс-хиагт, бэлчээрийн ургамлын тусгаг бүрхэц 10-15 хувь, 100 $м^2$ талбайд 10-17 зүйл ургамалтай.




*Зураг 3. Монгол орны байгалийн бүс бүслүүр*

Дундговь аймаг нь д.т.д. 1250-1700 метрийн өндөрт өргөгдсөн хойт хэсгээр Монгол Дагуурын уулын ойт хээрийн хэв шинж бага зэрэг нөлөөлсөн хээрийн хэвшил, өмнөд хэсгээр цөлөрхөг хээрийн нөлөө орсон болон зүүн, зүүн урд хэсгээр бэсрэг уулс, ухаа гүвээ толгодын ландшафттай нийтдээ тал хөндий, хотос хонхордуу газар зонхилон оршино.

Ургамалжилтын хувьд ерөнхийдөө толгодын ар хажуу хэсгээр харгана-алаг өвс ургамлын бүлгэмдэлтэй, харин тал хөндийн хэсгээр маш сийрэг алаг өвст, хотос хонхроор дэрс-хиагт, дэрс-улалжит хээрийн ургамалжил зонхилж, ихэнх хэсэг нь ургамалжлын ангиллаар хээрийн бүсийн хээр, цөлөрхөг хээрийн төлөөлөгч оролцсон бөгөөд дараах ургамалжилтын бүлгэмдэлдээ тэмдэглэгдсэн.

Тус аймгийн газар нутаг нь дараах ургамал бүлгэмдэл ургана. Үүнд:

- Дундад Халхын хуурай хээрийн бүсийн элсэрхэг хүрэн хөрсөнд ургах Крыловын хялгана, дэрвээн хазаар өвс, ботууль-жижиг дэгнүүлт үетэн- харганат болон ботууль-хялганат хээр болно (Зураг 6).

*Зураг 6. Хялгана - жижиг дэгнүүлт үетэн - харганат болон*



*Хазаар өвс - хялганат хээр*

Энэ нь хуурай хээрийн бүсийн өмнөд хэсгийн хүрэн хөрсөнд ургах харгана (алтан харгана - *Caragana leucophloea*, тарваган харгана - *Caragana pygmaea*) бүхий жижиг дэгнүүлт үетэн- хялгана- таанат (зүүнгарын хазаар өвс - *Cleistogenes soongarica*, клеменцийн хялгана - *Stipa klemenzii*, хөмөл - *Allium mongolicum*) эвшил зонхилон ургана.

Дундад Халхын хээрт хамаарах зарим хэсэгт говийн бэсрэг уул толгодын хоорондох элсэрхэг хүрэн болон хар хүрэн хөрстэй газар хазаар өвс- жижиг дэгнүүлт үетэн- агьт болон хялгана- агьт хээр бий. Үүнд: Монголын төв хэсгийн клеменцийн хялгана - *Stipa klemenzii*, өлчир шарилж - *Artemisia frigida*, дэгнүүлт шарилж - *A. caespitosa*, алтан харгана - *Caragana leucophloea*, тарваган харгана - *Caragana pygmaea* оролцсон, дэрвээн хазаар өвс - *Cleistogenes squarrosa* бүхий жинхэнэ хуурай хээр оршино (Зураг 7).

Мөн Дундговийн цөлөрхөг хээрийн тойргийн тэгш өндөрлөг, бэсрэг уулсын хайргархаг, элсэрхэг бор хөрсөнд ургах баглуур-таана- хялганат (сайрын хялгана - *Stipa glareosa*, говийн хялгана - *S. gobica*, таана - *Allium polyrrhizum*, ахар навчит баглуур - *Anabasis brevifolia*) хээр өмнөт хэсэгт зонхилно (Зураг 8).





Тус нутгийн хойноос зүүн өмнөд хэсгийг дагаж хуурай хээрийн дэгнүүлт үетэнт, хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, хялгана-агьт хээр тааралдаж байхад, нутгийн зүүн хойт хэсэгт сайр чулуурхаг хар хүрэн, хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс- хялганат хээр, өмнөд хэсгээр говийн бор хөрстэй хялгана-хазаар өвст, хялгана-таана-баглуурт цөлөрхөг хээр илэрдэг онцлогтой.

ДУНДГОВЬ АЙМГИЙН УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ

Монгол орны ургамал-газарзүйн Дундад Халх, Дорноговийн тойргуудын хээрийн бүсийн тодорхой газар нутгаар буюу Дундговь аймагт судалгаа явуулсан болон урьд жилүүдийн хийсэн судалгаа ургамлын цуглуулга, бичиглэлийг харьцуулан боловсруулж 39 овогт хамаарах 123 төрлийн 202 зүйл ургамал бүртгэв. Энэ нь ургамлын судалгааг ургамал ургалтын үеэс хожуу хийсэнтэй холбоотой байж болох юм. Эдгээр бүртгэсэн зүйл ургамлын дотор **НЭН ХОВОР 6 ЗҮЙЛ, ХОВОР 10 ЗҮЙЛ, ЭНДЕМИК 3 ЗҮЙЛ, СУБЭНДЕМИК УРГАМАЛ 13 ЗҮЙЛ, АШИГЛАЛТАНД ӨРТӨМТГИЙ АШИГТ УРГАМАЛ 27 ЗҮЙЛ УРГАМАЛ БАЙВ.**

Дундговийн ургамлын аймагт Нангиад зээргэнэ - *Ephedra sinica* Stapf., алтан харгана - *Caragana leucophloea Pojark.*, тарваган харгана - *Caragana pygmaea* (L.) DC., бариулт Бүйлэс - *Amygdalus pedunculata* Pall. зэрэг сөөг сөөгөнцөр; гялгар дэрс - *Achnatherum splendens* (Trin.) Nevski., говийн хялгана - *Stipa. gobica* Roshev., дэрвээн хазаар өвс – *Cleistogenes. squarrosa* (Trin.) Keng., саман ерхөг - *Agropyron cristatum* (L.) P.B., нангиад түнгэ - *Leymus chinensis* (Trin.) Tzvel., хөмөл - *Allium mongolicum* Regel., таана - *A. polyrrhizum* Turcz. ex Rgl., цагаалин цахилдаг - *Iris lacteal* Pall., олслиг халгай - *Urtica cannabina* L., шоргор лууль - *Chenopodium aristatum* L., цагаан лууль - *Ch. album* L., толгодын бударгана - *Salsola collina* Pall., маралнавчит гичгэнэ – *Potentilla tanacetifolia* Willd. ex Schlecht., ацан ажигана - *Stellaria dichotoma* L., сиверсийн шарилж – *A. sieversiana* Willd., ишгэн шарилж - *Artemisia dracunculus* L., өлчир шарилж – *A. frigida* Willd. зэрэг олон наст өвс зонхилон ургана.

**Цаашид анхаарах асуудлууд:**

- Дундговь аймагт ургаж буй нэн ховор, ховор ургамал нь байгаль экологийн хүчин зүйлээс хамаарч ховордож буй ургамал (Алтан бэрмэг, Сөөгөн шимэрс, Шивлээхэй зээргэнэ, Монгол догар г.м.), хүн амьтан нөлөөллөөс ховордож буй ургамал (Нангиад зээргэнэ, Толбот бэрээмэг, Ацан ажигана, Сибирь ерөндгөнө, г.м.) буй бөгөөд энэ бүс нутагт **нэн ховор 6 зүйл, ховор 10 зүйл, Эндемик 3 зүйл, Субэндемик ургамал 13 зүйл, ашиглалтанд өртөмтгий ашигт ургамал 27 зүйл ургамал** тохиолдоно.

- Ашигт (дотоодод хэрэглэгдэж байгаа эмийн болон экспортоор гаргаж байгаа) ургамлын нөөц ашигласны төлбөр, зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн тохиолдолд экологи-эдийн засгийн үнэлгээний төлбөрийг яаралтай мөрдөж хэрэгжүүлэх.
- Дундговь аймгийн өвөрмөц ургамалжилт бүхий Их Адаацаг болон Их газрын чулуу, Бага газрын чулуунд “байгалийн цэцэгт ургамлын хүрээлэн” байгуулж тэнд байгалийн аясаар болон зориудаар зарим ургамлыг шилжүүлэн байршуулах, нутагшуулах улмаар нөхөн сэргээх.

Тархац нөөц багатай ашиглалтад өртөмхий ашигт ургамлыг улсын болон орон нутгийн хамгаалалтад авах, нэн ховор болон ховор ургамлыг үр болон тарималжуулах байдлаар үржүүлэн, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагатай байна.

## 2.8. АМЬТНЫ НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Амьтны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах чиглэлээр Амьтны тухай хууль болон холбогдох эрх зүйн акт мөрдөгдөж, Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах хөтөлбөр, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр тус тус хэрэгжүүлж байна.

### 2.9.1. Амьтны нөөц

Монгол оронд 141 зүйл хөхтөн амьтан, 513 зүйл шувуу, 21 зүйл мөлхөгч, 6 зүйл хоёр нутагтан, 74 зүйл загас, 13 мянга гаруй зүйлийн сээр нуруугүйтэн бүртгэгдээд байна. Монгол орны амьтны аймгийн 2018 оны зүйлийн бүрдлийг 1998, 2016 оныхтой харьцуулж үзвэл зүйлийн тоо нь өссөн байна. Сүүлийн 20 гаруй жилийн судалгааны дүнгээр Монгол орны нэн ховор, ховор амьтан болох мазаалай баавгай багадаа 28, хүрэн байвгай 500, баданга хүдэр 6500, Төв Азийн минж 300, голын халиу 100, суусар булга 3500, цоохор ирвэс 900-1200, тахь 649, халиун буга 10000 орчим, хулан 10000, янгир 11000, аргаль 13000, молцог хандгай 16400, хавтгай тэмээ 800-1200, цаа буга 140-200, хар сүүлт 12000, зэрлэг гахай 35000, Монгол бөхөн 4000 гаруй тоо толгой тус тус байгаа бол цагаан зээр 3 сая орчим байна.

/Сүүлийн 10 жилд улсын хэмжээнд амьтны нэгдсэн тооллого, үнэлгээ хийгээгүй. Зөвхөн зарим амьтны тоо толгой, тархац, ашиглалтын нөөцийг монгол орны хэмжээгээр зохион байгуулсан байна./

Дундговь аймагт 12 зүйл хөхтөн амьтан, 23 зүйл шувуу, 2 зүйл мөлхөгч, 864 орчим зүйлийн шавьж бүртгэгдээд байна. Нэн ховор амьтнаас аргаль хонь, янгир ямаа, ховор амьтнаас хар сүүлт байна.

***Үүнээс цагаан зээр 36336 тоо толгой, хар сүүлт 133 тоо толгой, аргаль хонь 1212 тоо толгой, янгир ямаа 771 тоо толгой, монгол тарвага 206 тоо толгой, саарал чоно 488 тоо толгой, шар үнэг 1152 тоо толгой, хярс 882 тоо толгой, монгол ногтруу 23593 тоо толгой, дагуур ятуу 25188 тоо толгой тархан нутаглаж байна.***

**“Эко үйлчилгээ” ТББайгууллагаар гүйцэтгүүлэн зарим амьтны тоо толгой, тархац, ашиглалтын нөөцийн судалгааг 2017 онд байгаль хамгаалах, нөхөн сэргээх, арга хэмжээний зардлаар хийв. Үүнд:**

***Цагаан зээр***

Хээрийн судалгааны дүнд 2017 оны 6 сарын байдлаар ***Дундговь аймгийн цагаан зээрийн тархац, байршил бүхий 41201,4 км$^{2}$ нутагт 36336.25 толгой цагаан зээр нэгж талбайд 11.5±9.9 нягтшилтай***гаар тархан нутаглаж байгааг тодруулав.

Өмнөх судлаачдын мэдээ баримт, судалгааны үр дүнд тулгуурлан үзвэл Дундговь аймгийн нэр бүхий сумдын нутагт хавар, зуны улиралд байрших цагаан зээрийн тоо толгойн хөдлөл зүйг тооцоолон үзвэл ***хавар, зуны улиралд нэгж талбайд 11.5±9.9 бодгаль ногдох нягтшилтайгаар 24244-72672 тархан байрших*** боломжтой байна.

***<u>Хар сүүлт</u>***

Дундговь аймгийн нутагт хар сүүлт нь таана-хөмөл-үетэнт, заг-бударганат, үетэн элдэв өвст зэрэг шүүслэг ургамал бүхий говийн уулсын бэлийн сайр, садарга, жижиг аараг толгод тэдгээрийн ам хөндий зонхилсон нэр бүхий газрыг тархан байршиж байна.

***<u>Аргаль хонь</u>***

Аргаль хонь нь аймгийн нутагт 85 сүрэгт хамрагдах 656 бодгаль тэмдэглэгдсэн бол харин аргаль хонины байршил бүхий Хулд, Луус, Говь-Угтаал зэрэг сумдын нэр бүхий газруудад 12 удаа ажиглалт хийхэд нэг ч аргаль хонь тохиолдоогүй байна.

Дундговь аймгийн нутагт аргаль хонины нөөцийг судалгаагаар тогтоогдсон аргаль хонины тоо толгойн байдлаас тооцоолон үзвэл ***7521,21 км$^{2}$ нутагт тархан байршиж байна.***

**<u>Янгир ямаа</u>**

Дундговь аймгийн хэмжээнд янгир ямаа тархан байрших экологийн нөхцөл бүхий нутгийн хэмжээ 5003.1 км$^2$ (цөм байршил 1311.8 км$^2$) буюу өмнөх судалгааны дүнгээс 27.3 хувиар илүү байгаа нь янгир ямааны тогтвортой байршил нутгийн хэмжээ нэмэгдэж буйг харуулна.

Дундговь аймгийн нутагт янгир ямааны нөөцийг судалгаагаар тогтоогдсон янгир ямааны тоо толгойн байдлаас тооцоолон үзвэл ***2836.18 км$^2$ нутагт тархан байрших*** боломжтой.

***Монгол тарвага***

2017 оны 5-6 сард хийсэн судалгааны дүнд үндэслэн үзвэл Дундговь аймгийн нутагт ***674.7 км$^2$*** талбайд байршин амьдарч байна.

Судалгааны дүнгээс үзвэл Дундговь аймгийн нутаг дэвсгэрт 1788.84 км$^2$ талбайд тарвага тархан байрших экологийн нөхцөлтэй болох нь тогтоогдсон бөгөөд сэргээн нутагшуулсан болон судалгаагаар ажиглагдсан монгол тарваганы дүнд үндэслэн үзвэл 674.78 км$^2$ нутагт 740 толгой монгол тарвага идээшин нутагладаг нь тогтоогдлоо. Эдгээр монгол тарвага тархсан нутгийн талбайд 100 га буюу 1 км$^2$ талбайд дунджаар 10.9 тарвага ноогдох нягтшилтай байна.

**Саарал чоно**

Аймгийн хэмжээнд 27037.93 км2 нутагт 488±32 толгой саарал чоно 1000 га-д 0.1 бодгаль ногдох нягтшилтай тархан амьдрах боломжтой байна. Сүүлийн жилүүдэд чонын тоо толгой өсөж байгаа бөгөөд саарал чонын малд халдах байдал тус аймгийн Гурвансайхан, Адаацаг, Өлзийт сумдын нутагт намрын улиралд ихээр нэмэгдэж байгаа талаар орон нутгийн иргэд мэдээлж байсан.

**Шар үнэг**

Аймгийн хэмжээнд 30830.66 км2 нутагт 1152±29 толгой шар үнэг 1000 га-д 0.3 бодгаль ногдох нягтшилтай байна.

Аймгийн хэмжээнд 37268.82 км$^2$ нутагт 882±130 толгой хярс үнэг 1000 га-д 0.2 бодгаль ногдох нягтшилтай байна.

***Бор туулай***

Хад чулуут бэсрэг уул, ухаа толгодын гуу жалга, дэрс-шавагт хотос, харганат хөндийд элбэг тохиолдоно. Судалгааны явцад 15 туулай ажиглагдсан.

**Боролзон туулай**

Аймгийн хэмжээнд 20751±1547 боролзон туулай тархан байршиж байна

**Монгол ногтруу**

Аймгийн хэмжээнд 23593±869  монгол ногтруу тархан байршиж байна.

**Дагуур ятуу**

Аймгийн хэмжээнд 25188±754  дагуур ятуу тархан байршиж байна.

### 2.9.2. АН АМЬТАН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Дундговь аймгийн хэмжээнд Баянжаргалан, Өлзийт, Гурвансайхан, Сайхан-Овоо,  Дэлгэрхангай, Өндөршил, Адаацаг зэрэг сумдад Агнуурын бүс нутгийг тогтоож, менежментийн төлөвлөгөөгөө батлуулсан.







Агнуурын бүс нутгийн судалгаа

| № | Сумын нэр | Агнуурын бүсийн нэр | Менежмент хариуцагч ААНэгжийн нэр | Засаг даргатай гэрээ байгуулсан эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 8 | 13 |
| 1 | Өлзийт | Уул алтаргана | “Нью жуулчин турс” ХХК | + |
| 2 | Баянжаргалан | Аргын хад, Шивээгийн уул | “Аанар” ХХК | + |
| 3 | Гурвансайхан | Гурвансайхан | Би Ти энд Ти Си ХХК | + |
| 4 | Сайхан-Овоо | Ахар уул | Натурал ай эн эн ХХК | + |
| 5 | Дэлгэрхангай | Улаан хад | Натурал ай эн эн ХХК | + |
| 6 | Өндөршил | Их уул | Би Ти энд Ти Си ХХК | + |
| 7 | Өлзийт | Дэл хөнжил Баянхайрхан нөхөрлөл | “Аанар” ХХК | + |

**Агнуурын бүс нутаг дах хяналт шалгалт**

Ангийн бүс нутаг бүхий 6 сумдын байгаль хамгаалагч нар хариуцсан талбайдаа тогтмол эргүүл шалгалт хийж, хамтарсан хяналт шалгалт нийт 41 удаа хийсэн байна. Байгаль орчны хяналтын улсын байцаагч нар нийт 34 удаа эргүүл шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтын явцад 187 тээврийн хэрэгсэл, 194 иргэдийг хамруулсан байна.






“Би Ти эн ТИ Си” ХХК, “Аанар ХХК”, “Нью жуулчин ХХК” агнуурын мэргэжлийн байгууллагууд ан амьтан ашигласны төлбөрийн хураамжийг хуулийн дагуу байршуулав. Ангийн орлого 2020 онд 192.4 сая.төгрөг, 2021 онд 402.6 сая.төгрөг, 2022 онд 639.9 сая.төгрөг төвлөрсөн. Агнуурын мэргэжлийн байгууллагууд 6 сумын 6 бүсэд 8-10 сарын хооронд агнуур зохион байгуулалтын ажлыг, 3, 4, 10 дүгээр саруудад мониторинг судалгаа, 1, 2, 11,12 дугаар саруудад биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.




***<u>Био техникийн арга хэмжээ</u>*.**

Тус аймгийн 8 сум, улс, орон нутгийн тусгай хамгаалалттай 4 газар, 6 агнуурын бүсэд **37** удаагын давтамжтай 511 боодол өвс, 12 тонн хужир, мараа тавьж зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авсан. Тусгай хамгаалалттай 8 газарт зэрлэг амьтан ажиглах камер байрлуулж, зэрлэг амьтдын хоол тэжээлийн байдал, хууль бус ан зэргийг хянах боломжтой болов.Мөн Сайхан-Овоо сумын агнуурын бүс гандуу, хуурайшилтай байсан тул зэрлэг амьтдын хорогдлоос сэргийлж шинээр 1 уст цэг, Өлзийт сумын Хөтлийн усанд шинээр 1 уст цэг нийт 2 уст цэг байгуулсан. Хувийн хэвшлийн 4.0 сая төгрөгийг зарцуулав.




Аймгийн агнуур зохион байгуулалтын ерөнхий судалгаа 2023 онд хийгдэнэ.

## 2.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН БАЙДАЛ

Дундговь аймгийн хэмжээнд Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 2021 онд хууль бусаар ашигт малтмал олборлох 8, хууль бусаар ан агнах 1, хууль бусаар мод бэлтгэх 2 нийт 11, 2022 онд хууль бусаар ашигт малтмал олборлох 5, химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах 1, хууль бусаар ан агнах 1 нийт 7 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. (Дундговь аймгийн Цагдаагийн газар)

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

# 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДОЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨВ

## 3.1. АГААРЫН БОХИРДОЛ

### *5.1.4. Агаарын чанарын индекс:*

4. 2022 онд тоос тоосонцрын багажтай болж, 1 дүгээр сарын 1-ээс 7 хоног бүр хүхэрлэг хий, азотын давхар исэл, тоос тоосонцрын /pm2.5/ дундаж үзүүлэлтийг УЦУОШТөвд хэмжин гаргаж байна. Дээрх үзүүлэлтийг агаарын чанарын индексээр үнэлэхэд 50 буюу цэвэр хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй гэсэн ангилалд хамаарч байна.

| Агаарын чанарын индекс | Агаарын чанарын ангилал | Тэмдэглэгээ (өнгөөр) | Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл |
|---|---|---|---|
| 0 - 50 | Цэвэр | Ногоон | Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. |
| 51-100 | Хэвийн | Шар | Агаарын чанар шаардлага хангах боловч, зарим бохирдуулах бодисын нөлөөлөлд хэт мэдрэг хүмүүс өртөж болно. Тухайлбал: озон, нарийн ширхэглэгт тоосонцрын нөлөөллийн улмаас хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай. |
| 101 – 250 | Бага зэргийн бохирдолтой | Улбар шар | Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ. Зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд илүү өртөнө. |
| 251 – 400 | Дунд зэргийн бохирдолтой | Ягаан | Нийт хүн амын эрүүл мэндэд бага зэргийн сөрөг нөлөөлөл илэрч эхлэнэ. Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хүндээр илэрнэ. |
| 401- 500 | Их бохирдолтой | Хүрэн | Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл илэрнэ. |
| 501 < | Маш их бохирдолтой | Улаан | Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ. |



## МАНДАЛГОВЬ ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫН МЭДЭЭ

Тус төвийн байгаль орчны шинжилгээний лаборатори нь агаар дахь хүхэрлэг хий болон азотын давхар ислийн агууламжийг хэмжиж байна. Одоогийн байдлаар агаарын чанарын стандарт /MNS4585:2016/-ын хүлцэх агууламжийг давсан тохиолдол илрээгүй байна.

| № | Он | Агаар бохирдуулагч бодисууд | |
|---|---|---|---|
| | | $NO_2$ мг/м$^3$ | $SO_2$ мг/м$^3$ |
| 1 | 2013 | 0.008 | 0.004 |
| 2 | 2014 | 0.012 | 0.007 |
| 3 | 2015 | 0.013 | 0.007 |
| 4 | 2016 | 0.012 | 0.007 |
| 5 | 2017 | 0.016 | 0.007 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | 2018 | 0.020 | 0.009 |
| 7 | 2019 | 0.021 | 0.008 |
| 8 | 2020 | 0.023 | 0.011 |
| 9 | 2021 | 0.019 | 0.010 |
| 10 | 2022 | 0.020 | 0.009 |
| ***Хүлцэх агууламж MNS 4585:2016*** | | ***0.20 мг/м³*** | ***0.450 мг/м³*** |




Дундговь аймгийн УЦУОШТөвийн БОШЛаборатори

**АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ**

Аймгийн хэмжээнд 2021 онд нийт 15338 тээврийн хэрэгсэл тоологдсон. Үүнээс сайнцагаан суманд нийт тээврийн хэрэгсэл болон мотоцикл 4810, Эрдэнэ-далай нийт 1760, Өндөршил 491, Хулд 1311, Луус 846, Дэрэн 565, Баянжаргалан 395, Говь-угтаал 535, Дэлгэрхангай 842, Өлзийт 867, Сайхан-овоо 624, Адаацаг 634, Цагаандэлгэр 320, Дэлгэрцогт 536, Гурвансайхан 802 тоологдсон байна.

/Аймгийн автотээврийн газраас тээврийн хэрэгслийн судалгааг 2021 оны 03 сарын байдлаар авсан.

| № | Аймаг дүүргийн нэр | Нийт тээврийн хэрэгсэл | Зориулалт | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суудал | Ачаа | Нийтийн тээвэр | Тусгай зориулалт | Мотоцикль | Цистерн | Зүтгүүр |
| 1 | Адаацаг | 634 | 249 | 214 | 14 | 3 | 153 | 1 | |
| 2 | Баянжаргалан | 395 | 170 | 148 | 10 | 2 | 64 | 1 | |
| 3 | Говь-Угтаал | 535 | 199 | 189 | 7 | 2 | 138 | | |
| 4 | Гурвансайхан | 802 | 315 | 292 | 24 | 17 | 150 | 3 | 1 |
| 5 | дэлгэрхангай | 842 | 297 | 193 | 27 | 7 | 317 | 1 | |
| 6 | Дэрэн | 565 | 244 | 218 | 12 | | 91 | | |
| 7 | Дэлгэрцогт | 536 | 229 | 180 | 10 | 4 | 113 | | |
| 8 | Луус | 846 | 316 | 203 | 15 | 5 | 306 | 1 | |
| 9 | Өндөршил | 491 | 249 | 187 | 5 | 5 | 45 | | |
| 10 | Өлзийт | 867 | 438 | 268 | | 9 | 152 | | |
| 11 | Сайхан-овоо | 624 | 249 | 207 | 22 | 7 | 138 | 1 | |
| 12 | Сайнцагаан | 4810 | 2785 | 857 | 190 | 76 | 872 | 10 | 20 |
| 13 | Цагаандэлгэр | 320 | 129 | 112 | 6 | 5 | 68 | | |
| 14 | Хулд | 1311 | 490 | 304 | 25 | 12 | 472 | 3 | 5 |
| 15 | Эрдэнэ-далай | 1760 | 594 | 591 | 43 | 26 | 504 | 2 | |
| | **НИЙТ** | 15338 | 6953 | 4163 | 410 | 180 | 3583 | 23 | 26 |

*Зураг 5. Тээврийн хэрэгслийн тоо*

Дээрх графикаас харахад хүн ам ихтэй газар машины тоо хэмжээ дагаж өссөн харагдаж байна. Үүнээс үзэхэд жил ирэх тусам хүн ам ихсэж айл өрхийн тоо нэмэгдэж  жилд хэрэглэх түлшний хэмжээ өсөж байгаа нь агаарын бохирдол ихэсгэх томоохон шалтгаан болж байна.

## УУРЫН ЗУУХНЫ ЯНДАНГИЙН УТАА ШҮҮГЧ

БОАЖЯамнаас санхүүжүүлэн “Регал инженеринг” ХХК-тай гэрээ байгуулсны дагуу “Дундговь –Ус” ОНӨҮГ-ын 2 дугаар зууханд 3, “Тэвшийнговь” ХХК-ийн 1 дүгээр зууханд 1, “Ган-Илч” ХХК-ийн 1 дүгээр зууханд 4, нийт төвлөрсөн халаалтын 8 янданд утаа шүүгч байршуулах ажил хийгдсэн. Улсын төсвийн 608.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан.




***5.1.3 Агаарын чанарыг сайжруулах бүс:***

Мандалговь хотын “Агаарын чанарыг сайжруулах бүсэд дагаж мөрдөх журам”-ыг БОАЖЯамны сайд, Дундговь аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/427, А/404 тоот хамтарсан тушаал, захирамжаар шинэчлэн батлуулсан бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэм хэмжээний актаар бүртгүүлэхээр Хууль зүйн яаманд хүргүүлсэн. Энэхүү журам батлагдсанаар гэр хорооллын айл өрхийг шөнийн цахилгааны тарифын хөнгөлөлт эдлэх боломж бүрдэж байна.

### 4.1. Усны бохирдол

Сайхан-Овоо сумын Онги Сайхан-Овоо усны харуул нь 1 цэгт физик шинж чанарын үзүүлэлтийг өдөр бүр хэмжиж байна. Байгаль орчны шинжилгээний лаборатори нь Онги Сайхан-Овоо усны харуулаас 4-11 саруудад ирүүлсэн дээжинд гадаргын усны чанарын хяналт шинжилгээг хийдэг. Хяналт шинжилгээгээр 2021, 2022 онд Онги гол нь 2-р зэргийн буюу цэвэр байсан байна.

Дундговь аймгийн Онги голын усны чанар 2021-2022 он

| Голын нэр | Харуулын нэр | Сорьц авсан он, сар, өдөр | Усны орчин, pH | Цахилгаан дамжуулах чанар, EC, uS/см | Жинлэг дэх бодис, W мг/л | Перманганатын исэлдэх чанар (ПИЧ)мг/л | Хатуулаг, мг-экв/л | Кальци (Ca), мг/л | Магни (Mg), мг/л | K+Na (мг/л) | Сульфат (SO4), мг/л | Хлор (Cl), мг/л | Гидрокарбонат HCO3 (мг/л) | Эрдэсжилт, мг/л | Аммони NH4, мг/л | Нитрит NO2, мг/л | Нитрат NO3, мг/л | Фосфор P мг/л | Фтор(F), мг/л | Төмөр Fe мг/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Онги-гол | Сайхан-овоо | 2021.04.06 | - | 351 | 145.6 | 3.5 | 2.93 | 34.3 | 14.8 | 31 | 48.3 | 12.8 | 170.8 | 312 | 0.35 | 0.027 | 0.19 | 0.076 | 0.58 | 0.25 |
| | | 2021.05.07 | 8.043 | 280 | 84.8 | 8.1 | 2.05 | 35.1 | 3.6 | 25.8 | 30.8 | 4.3 | 141.6 | 241.2 | 0.21 | 0.027 | 0.12 | 0.007 | 0.62 | 0.17 |
| | | 2021.06.04 | 8.12 | 387 | 115.2 | 2 | 3.15 | 35.9 | 16.5 | 29.3 | 43.3 | 12.1 | 187.9 | 325 | 0.08 | 0.002 | 0.06 | 0.01 | 0.54 | 0.08 |
| | | 2021.07.02 | 8.25 | 420 | 2.8 | 0.7 | 3.89 | 36.9 | 24.9 | 15.8 | 50.9 | 10.6 | 192.8 | 331.9 | 0.03 | 0.003 | 0.21 | 0.015 | 0.6 | 0.03 |
| | | 2021.08.04 | 8.209 | 330 | 20.8 | 3.9 | 2.83 | 39.5 | 10.5 | 24.5 | 30.4 | 14.9 | 168.4 | 288.2 | 0.2 | 0.004 | 0.24 | 0.022 | 0.42 | 0.26 |
| | | 2021.09.13 | - | 277 | 4 | 2.9 | 2.3 | 13.2 | 19.9 | 19 | 38.4 | 3.5 | 131.8 | 225.8 | 0.04 | 0.016 | 0.23 | 0.029 | 0.45 | 0.03 |
| | | 2021.10.06 | 8.13 | 285 | 70.8 | 2 | 2.46 | 40.3 | 5.5 | 18 | 34.6 | 5 | 141.6 | 245 | 0.04 | 0.009 | 0.07 | 0.011 | 0.51 | 0.09 |
| | | 2021.11.02 | 8.68 | 264 | 1.6 | 3.3 | 2.62 | 32.1 | 12.4 | 17.8 | 52.1 | 4.3 | 130 | 248.7 | 0.17 | 0.009 | 0.63 | 0.048 | 0.32 | 0.59 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Онги-гол | Сайхан-овоо | 2022.04.09 | 8.78 | 342 | 46.8 | 8.2 | 2.5 | 35.3 | 9 | 33 | 54.9 | 4.3 | 156.2 | 292.7 | 0.47 | 0.054 | 0.91 | 0.033 | 3.84 | 0.71 |
| | | 2022.05.01 | 9.16 | 275 | 26 | 3 | 2.54 | 34.5 | 10 | 20.3 | 38.7 | 5 | 146.2 | 254.9 | 0.16 | 0.006 | 0.56 | 0.004 | 0.67 | 0.25 |
| | | 2022.06.05 | 8.28 | 345 | 13.6 | 1.1 | 2.63 | 39.1 | 8.3 | 35.5 | 53.2 | 8.5 | 164.7 | 309.3 | 0.06 | 0 | 0.15 | 0.007 | 0.47 | 0.03 |
| | | 2022.07.25 | 7.41 | 357 | 0.8 | 0.3 | 2.93 | 43.1 | 9.5 | 37.5 | 64 | 9.2 | 173.3 | 336.6 | 0.04 | 0.009 | 0.24 | 0.015 | 0.59 | 0.34 |
| | | 2022.08.15 | 8.06 | 400 | 3.6 | 2.1 | 2.77 | 39.9 | 9.5 | 37.8 | 52.9 | 10.6 | 175.7 | 326.4 | 0.1 | 0.006 | 1.12 | 0.015 | 0.5 | 0.14 |
| | | 2022.09.1 | 8.79 | 350 | 6 | 0.9 | 2.96 | 43.1 | 9.8 | 31 | 41.3 | 12.8 | 181.8 | 319.8 | 0.08 | 0.005 | 0.23 | 0.009 | 0.7 | 0 |
| | | 2022.10.19 | 7.871 | 285 | 16 | 0.6 | 3 | 39.1 | 12.8 | 13 | 22.2 | 4.3 | 166 | 265.2 | 0.17 | 0.009 | 0.1 | 0.016 | 0.89 | 0.05 |
| | | 2022.11.04 | 7.87 | 265 | 41.2 | 3.3 | 2.73 | 43.1 | 7.1 | 1 | 35.3 | 11.3 | 104.9 | 202.7 | 0.13 | 0.001 | 0.04 | 0.078 | 0.52 | 0.04 |

Усны чанарын зэрэг

| Усны харуул | Хугацаа | Усны бохирдлын инекс | Чанарын зэрэг, ангилал |
|---|---|---|---|
| Онги Сайхан-овоо | 2021 | 0.31 | II Цэвэр |
| | 2022 | 0.34 | |

Хөрсний бохирдол

| | | | Хөрсний агрохимийн шинжилгээ | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| № | Дээж авсан огноо | **Дээж авсан газрын нэр** | **Кординат** | Ялзмаг [%] | SO4 [мг/кг] | NO3 [мг/кг] | NH4 [мг/кг] | P2O5 [мг/кг] |
| 1 | 2021.10.05 | Өлзий Дундговь компаниас хойш 200м | E106º16.166’ N45045.960’ | 0.88 | 60.7 | 13.91 | 20.7 | 4.14 |
| 2 | | Цаг уурын хашаан дотроос | E106º16.508’ N45º46.038’ | 0.98 | 88.6 | 5.64 | 12.07 | 5.71 |
| 3 | | Гол цэцэрлэг, Аймгийн зөвлөлийн урд талаас | E106º16.407’ N45º46.048’ | 1.23 | 58.2 | 9.59 | 14.66 | 4.93 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | Под станцын баруун тал 100м | E106º16.684’ N45º45.898’ | 1.02 | 156.5 | 7.9 | 33.63 | 3.19 |
| 5 | | Хогийн цэг орчим | E106⁰16’56.6’’ N45⁰44’59.1’’ | 0.42 | 1446.2 | 13.82 | 46.56 | 4.26 |
| 6 | | Найрамдлын хөшөөний дэргэдээс | E106º16.180’ N45º46.139’ | 0.39 | 42.5 | 6.67 | 22.42 | 7.06 |
| 7 | | НИК ШТС-ийн баруун хойно 50м | E106º16.291’ N45º45.658’ | 0.25 | 48.5 | 0.75 | 42.25 | 6.33 |
| 8 | | 5-р цэцэрлэгийн хашааны баруун талаас | E106º15.897’ N45045.633’ | 1.58 | 38.8 | 10.06 | 25.01 | 5.26 |
| 9 | | 4-р цэцэрлэгийн урд талаас | E106º16.015’ N45045.891’ | 1.12 | 42.5 | 15.6 | 25.01 | 5.66 |
| 10 | | Сүмийн баруун хойно | E106º16.544’ N45º46.276 | 0.25 | 74 | 6.96 | 6.04 | 6.27 |
| 11 | | 8 жилийн сургуулийн хашааны урд тал | E106º16.392’ N45º46.469’ | 0.42 | 32.8 | 5.45 | 37.94 | 6.1 |

## Хөрсний чанарын төлөв байдлын тойм

Мандалговь хотын 11 цэгээс 2 жил тутам хөрсний дээж авч, агрохими болон хүнд металлын шинжилгээ хийж, хөрсний бохирдлыг хянаж байна. Хамгийн сүүлийн байдлаар 2021 онд хөрсний шинжилгээг хийсэн болно.

Энэхүү хяналт шинжилгээгээр хөрсөн дэх кадмий, хартугалга, мөнгөн ус, бром, хром, цайр, зэс, кобальт, стронций, рубиди, циркон, хлор зэрэг 12 хүнд металлыг рентгенфлоурсценцийн спектрофотометр ашиглан 1 кг хөрсөнд агуулагдах агууламжийг тодорхойлсон болно.

2021 онд Дундговь аймгийн хөрсний хяналт шинжилгээний дүн мэдээг хөрсний чанарын MNS 5850:2008 стандарттай харьцуулахад хүнд металлуудын агууламж хүлцэх агууламжаас давсан тохиолдол алга байна.

Хөрсний хүнд металлын шинжилгээ

| № | Дээж авсан огноо | Дээж авсан газрын нэр | Кординат | Cl мг/кг | Cd мг/кг | Pb мг/кг | Hg мг/кг | Br мг/кг | Cr мг/кг | Zn мг/кг | Cu мг/кг | Co мг/кг | Sr мг/кг | Rb мг/кг | Zr мг/кг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | 8 жилийн сургуулийн хашааны урд тал | E106º16.392’ N45º46.469’ | 0 | 0 | 18.4 | 0 | 1.5 | 0 | 91.8 | 24.7 | 27.8 | 451.4 | 188.9 | 252.6 |
| 2 | | Сумийн баруун хойно | E106º16.544’ N45º46.276 | 0 | 1.1 | 27.8 | 0 | 0 | 0 | 92.9 | 26.7 | 14.4 | 465.9 | 172.9 | 327.3 |
| 3 | | Под станцын баруун тал 100м | E106º16.684’ N45º45.898’ | 0 | 1.4 | 16.2 | 0 | 0 | 4.7 | 78.4 | 25.6 | 24.3 | 485.5 | 1963 5 | 196.2 |
| 4 | | Өлзий Дундговь компаниас хойш 200м | E106º16.166’ N45045.960’ | 0 | 0 | 11.3 | 0 | 0 | 0 | 47.4 | 29.7 | 22.9 | 550.2 | 194.7 | 280.2 |
| 5 | | НИК ШТС-ийн баруун хойно 50м | E106º16.291’ N45º45.658’ | 0 | 1.3 | 27.4 | 0.4 | 0 | 0 | 117.2 | 26.9 | 17.6 | 539.4 | 200.3 | 321.4 |
| 6 | 2021.10 .05 | 5-р цэцэрлэгийн хашааны баруун талаас | E106º15.897’ N45045.633’ | 0 | 0.8 | 30.1 | 0 | 0 | 4.3 | 111.2 | 27.9 | 22.3 | 417.8 | 185.3 | 212.2 |
| 7 | | 4-р цэцэрлэгийн урд талаас | E106º16.015’ N45045.891’ | 0 | 0.4 | 29.3 | 0 | 0 | 5.7 | 98.2 | 27.3 | 22.2 | 532.5 | 195.8 | 256 |
| 8 | | Найрамдлын хөшөөний дэргэдээс | E106º16.180’ N45º46.139’ | 0 | 0 | 26.9 | 1.2 | 0 | 0 | 106.7 | 28.1 | 16.3 | 488.9 | 19.06 | 179.7 |
| 9 | | Гол цэцэрлэг, Аймгийн зөвлөлийн урд талаас | E106º16.407’ N45º46.048’ | 0 | 0 | 22.5 | 0 | 0 | 0 | 114.5 | 25.6 | 23.8 | 512.1 | 198.4 | 235.8 |
| 10 | | Цаг уурын хашаан дотроос | E106º16.508’ N45º46.038’ | 0 | 1.4 | 21.5 | 0.3 | 0 | 3.9 | 94.6 | 28.1 | 8.9 | 482.4 | 170.9 | 207.8 |
| 11 | | Хогийн цэг орчим | E106º16’56.6’’ N45º44’59.1’’ | 0 | 0 | 16.9 | 0 | 0 | 12.8 | 137.1 | 25.2 | 18.7 | 485.9 | 222.4 | 482.7 |
| | **MNS 5850:2019 Хүлцэх агууламж** | | | | **3** | **100** | **2** | | **150** | **300** | **100** | **50** | **800** | | |

## 4.2. ХОГ ХАЯГДАЛ

2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 15 хогийн цэг 138.30 га талбайг эзэлж байна. 4 суманд хог хаягдлын нэгдсэн цэгийг шууж булшлах ажил хийгдсэнээр өмнөх онтой харьцуулахад хогийн цэгийн талбай 5 га-аар багассан байна.

### 4.2.1. ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГТ ЗАЙЛУУЛСАН ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

Байгаль орчны захиргааны статистик маягтын дагуу 2021 онд 15 сумын төвлөрсөн хогийн цэгт 79194.70 тонн, 2022 онд 86,419.60 тонн хог хаягдлыг тус тус тээвэрлэсэн байна. /www.eic.mn/ Нийтийн эдэлбэр талбайн бүх нийтийн их цэвэрлэгээг 15 суманд 23 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 87 аж ахуйн нэгж, байгууллагын 3282 ажилчид, албан хаагчид, иргэдийг хамруулан нийт 261.3 га талбайгаас 422.5 тн энгийн хог хаягдлыг орон нутгийн төсвийн 0.8 сая төгрөгийн хөрөнгөөр цэвэрлэж хог хаягдлын нэгдсэн цэгт төвлөрүүлсэн.

### 4.2.2. ХОГ ХАЯГДЛЫН ДАХИН АШИГЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТЫН МЭДЭЭ

2021 онд аймгийн хэмжээнд 43.4 тонн хог хаягдлыг дахин ашиглаж, боловсруулсан бол 2022 онд Сайнцагаан суманд 8 тн, Сайхан-Овоо суманд 3.5 тн, Дэлгэрцогт суманд 2.5 тн, Луус суманд 3 тн, **4 сум**анд 3 төрлийн **17 тн** дахивар хог хаягдлыг дахивар нөөц авах цэгтээ ангилж цуглуулсан. Гурвансайхан суманд 35.5 тонн хог хаягдлыг дахин боловсруулж нийт 52 тонн хог хаягдлыг дахин ашиглаж, боловсруулсан нь нийт хог хаягдлын **0.06%-**ийг эзэлж байна. Хог хаягдал ангилан ялгах ажил үе шаттайгаар нэмэгдэж байна.

Сайнцагаан, Говь-угтаал, Сайхан-овоо, Баянжаргалан, Цагаандэлгэр, Дэрэн, Өлзийт, Луус, Гурвансайхан, Дэлгэрцогт, Өндөршил, Эрдэнэдалай сумдад хуванцар цуглуулах болон 3 төрлөөр ангилан ялгах, эмнэлгийн хог хаягдал ялгах зориулалт бүхий хогийн сав нийт 94 аж ахуйн нэгж, байгууллага шинээр байршуулж, аймгийн хэмжээний нийт ангилан ялгах хогийн сав 224 болж нэмэгдэв.


тонн
88000
86000
84000
82000
80000
78000
76000
74000
2021
2022
